



Конрад
Аденауэр
Сан



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР
**УДИРДЛАГЫН
АКАДЕМИ**

ЗАЛУУЧУУДЫН УЛС ТӨРИЙН ОРОЛЦОО

/18-35 НАС/

СУДАЛГААНЫ ТАЙЛАН





МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР
УДИРДЛАГЫН АКАДЕМИ

**ЗАЛУУЧУУДЫН
УЛС ТӨРИЙН ОРОЛЦОО**

/18-35 НАС/

Судалгааны тайлан

Захиалагч байгууллага: Конрад-Аденауэр-Сан

Гүйцэтгэгч: Удирдлагын академийн судалгааны баг

Хугацаа: 2016.02.15 - 2016.5.01

УЛААНБААТАР ХОТ
2016

АГУУЛГА

АГУУЛГА	3
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	4
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	6
СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ	7

НЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ТҮҮВЭР 9

1.1. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД.....	10
1.2. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ	11
1.3. СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ, ТҮҮВЭР	13

ХОЁР. ЗАЛУУЧУУДЫН УЛС ТӨРИЙН ОРОЛЦООНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ 15

2.1. СУДАЛГААНД ХАМРАГДСАН ЗАЛУУЧУУДЫН ХҮН АМ, ӨРХИЙН ШИНЖ БАЙДАЛ.....	16
2.2. ЗАЛУУЧУУДЫН УЛС ТӨРИЙН ОРОЛЦОО, ТҮҮНИЙ ХЭЛБЭРҮҮД.....	24
2.3. СОНГУУЛИЙН ТАЛААРХ ЗАЛУУЧУУДЫН ОЙЛГОЛТ, ТӨСӨӨЛӨЛ.....	36
2.4. СОНГУУЛИЙН ОРОЛЦОО, ЗАН ҮЙЛ, ХАНДЛАГА	43
2.5. УЛС ТӨРИЙН ТӨЛӨӨЛЛИЙН ТАЛААРХ ЗАЛУУЧУУДЫН ҮНЭЛГЭЭ	59

ДҮГНЭЛТ	73
ЗӨВЛӨМЖ	76
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	77

Зургийн жагсаалт

Зураг 1.	Судалгаанд хамрагдагсадын нас	17
Зураг 2.	Судалгаанд хамрагдагсадын хүйс	18
Зураг 3.	Судалгаанд хамрагдагсадын боловсролын түвшин	19
Зураг 4.	Судалгаанд хамрагдагсадын ажил эрхлэлтийн байдал	20
Зураг 5.	Судалгаанд хамрагдсад аймаг, нийслэлээр	21
Зураг 6.	Судалгаанд хамрагдагсадын өрхийн байршил	22
Зураг 7.	Судалгаанд хамрагдагсадын амьжиргааны түвшин	23
Зураг 8.	Залуучуудын улс төр сонирхох байдал	25
Зураг 9.	Залуучуудын улс төрийн өнөөгийн байдлын үнэлгээ	27
Зураг 10.	Залуучуудын улс төрийн оролцоо	28
Зураг 11.	Улс төрийн оролцооны түвшин, насны бүлгээр (дундаж)	29
Зураг 12.	Сонгуулийн оролцооны дундаж утга, боловсролын түвшингээр	31
Зураг 13.	Залуучуудын улс төрийн оролцооны хэлбэр	32
Зураг 14.	Залуучуудын улс төрийн оролцоо, насны бүлгээр	35
Зураг 15.	Сонгуулийн талаарх залуучуудын ойлголт, төсөөлөл	37
Зураг 16.	Сонгуулийн талаарх залуучуудын ойлголт, насны бүлгээр	39
Зураг 17.	Залуучууд сонгуулийн талаарх мэдээлэл авч буй эх сурвалж	40
Зураг 18.	Сонгуулийн талаарх мэдээлэл, сурталчилгааны олон нийтэд хүртээмжтэй байдал	42
Зураг 19.	Залуучуудын сонгуулийн оролцоо	43

Зураг 20.	Улс төрд оролцохгүй байх шалтгаан	44
Зураг 21.	Сонгуулийн одоогийн /холимог/ тогтолцооны талаарх залуучуудын үнэлгээ	46
Зураг 22.	Сонгуулийн санал авах үйл ажиллагаа сонгогчдод чирэгдэлгүй, үр дүнтэй зохион байгуулагдаж чадаж байгаа эсэх талаарх залуучуудын үнэлгээ	47
Зураг 23.	Сонгуулийн санал авах үйл ажиллагааны талаарх залуучуудын сэтгэл ханамж	48
Зураг 24.	Өнгөрсөн сонгуулиудын талаарх залуучуудын үнэлгээ	49
Зураг 25.	Сонгуулийн санал авах, тоолох үйл ажиллагаанд итгэж буй байдал	50
Зураг 26.	УИХ-ын 2016 оны ээлжит сонгуульд залуучууд оролцох эсэх	51
Зураг 27.	Сонгуулийн оролцооны дундаж утга (боловсролын түвшингээр)	52
Зураг 28.	Залуучууд сонгуульд оролцож саналаа өгөхдөө чухалчилж буй зүйлс	55
Зураг 29.	Сонгуульд нэр дэвшиж буй хүний талаарх залуучуудын хүлээлт	58
Зураг 30.	Тойргоосоо сонгогдсон төлөөлөгчдийг мэдэж буй байдал	60
Зураг 31.	Тойргоосоо сонгогдсон төлөөлөгчдийг мэдэж буй байдал /өрхийн байршлаар/ хувиар	61
Зураг 32.	Тойргоосоо сонгогдсон төлөөлөгчдийг мэдэж буй байдал (насны бүлгээр)	62
Зураг 33.	Тойргоос сонгогдсон төлөөлөгчдийн талаарх залуучуудын үнэлгээ	63
Зураг 34.	Тойргоос сонгогдсон төлөөлөгч сонгогчидтойгоо эргэх холбоотой ажиллаж чадаж байна уу?	65
Зураг 35.	Тойргоос сонгогдсон төлөөлөгчдийн талаарх залуучуудын үнэлгээ	66
Зураг 36.	Дараах байгууллагуудад залуучуудын төлөөлөл хангагдаж чадаж байна уу?	67
Зураг 37.	Өмнөх сонгуулиудын залуучуудын оролцоо	70-72

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1.	Нийслэл, орон нутгаас асуулгын судалгаанд хамрагдсан залуучуудын түүвэр олонлогийн хэмжээ, аймаг, дүүргээр.....	14
Хүснэгт 2.	Залуучуудын улс төрийн сонирхол (насны бүлгээр).....	26
Хүснэгт 3.	Залуучуудын улс төрийн оролцоо, насны бүлгээр.....	30
Хүснэгт 4.	Залуучуудын улс төрийн оролцоо, амьжиргааны түвшин	30
Хүснэгт 5.	Залуучуудын улс төрийн оролцооны идэвхи, оролцооны хэлбэрүүдээр.....	33
Хүснэгт 6.	Залуучуудын улс төрийн оролцооны хэлбэрүүд, насны бүлгээр.....	34
Хүснэгт 7.	Сонгуулийн талаарх залуучуудын ойлголт, төсөөлөл (боловсролоор)	38
Хүснэгт 8.	Залуучууд сонгуулийн талаарх мэдээлэл авч буй эх сурвалж, өрхийн байршлаар.....	41
Хүснэгт 9.	Өнгөрсөн сонгуулиуд өгсөн үнэлгээ нь залуучуудын 2016 оны сонгуулийн идэвхид нөлөөлж буй байдал.....	53
Хүснэгт 10.	Сонгуулийн тогтолцооны талаарх залуучуудын байр суурь, сонгогчдын зан үйлийн хамаарал.....	57

Судалгааны үндэслэл

Өнөө үед дэлхийн аль ч улс оронд залуучуудын хөгжлийн асуудалд төрийн байгууллагаас эхлээд олон нийт, иргэний нийгэм, судлаачид онцгой анхаарах болжээ. Монголын ардчиллын хөгжлийн тулгамдсан сорилтуудын нэг болсон иргэдийн оролцооны тухай асуудал өнөөдөр бодлого, эрх зүйн талаасаа ч, судалгаа боловсруулалтынхаа хувьд ч, нийгмийн улс төрийн амьдралын хэрэгцээ шаардлага талаасаа ч анхаарал татсан чухал сэдвийн нэг юм.

Конрад-Аденуаэр-Сангийн захиалгаар хийгдсэн энэхүү судалгаа нь залуучуудын улс төрийн оролцооны асуудлыг сонгуулийн үйл явцтай холбон илүү нарийвчлан судлах, ингэхдээ энэ талаарх төрийн бодлого, эрх зүйн орчин, залуу буюу шинэ сонгогчийн зан үйлийг тодруулах зорилго тавьсан болно. Энэ зорилгоо хэрэгжүүлэх хүрээнд дор дурьдсан чиглэлээр мэдээллийн сан бүрдүүлж дүн шинжилгээ хийлээ. Үүнд нэгд, улс төрийн оролцооны онол, үзэл

баримтлал болон Монголын залуучуудын улс төрийн оролцоо, сонгуулийн зан үйлийн өнөөгийн байдалд шинжилгээ хийх *хоёрт*, залуучуудын асуудлаар төрөөс баримталж буй бодлого, хөтөлбөрүүд болон эрх зүйн орчны өнөөгийн нөхцөл байдалд ерөнхий дүн шинжилгээ хийлээ. *Гуравт*, залуучуудын улс төрийн оролцоо, сонгуулийн зан үйлийн талаарх олон нийтийн санаа бодлыг тандан судлах санал асуулгын судалгааны үр дүнд шинжилгээ хийж ерөнхий дүр зураг гарахыг оролдло.

Улс төр, сонгуулийн оролцоо, сонгуулийн зан үйлийн судалгаа нь хууль эрх зүй, ёс суртахуун, сэтгэл зүй, социологийн үлэмж нарийн үзэгдлүүдтэй холбоотой байдаг учраас олон шинжлэх ухааны уулзварт оршиж, олон салбарын мэргэжлийн судлаачдын хамтын хөдөлмөрөөр хийгдэх том ажил юм. Манай орны хувьд сонгуулийн зан үйлийг тухайлан судлах ажил эхлэлийн төдий байгаа учраас бидний явуулсан энэ

судалгаа хэрэг дээрээ анхны зорилтод судалгаа байснаараа онцлог юм. Ийм учраас судлаж байгаа асуулынхаа ерөнхий зураглалыг гаргах, зарим тулгамдсан асуудлыг тодруулах, цаашид мэргэжлийн судлаачид, судалгааны байгууллагын анхаарлыг хандуулах зорилготой байсныг тэмдэглэж байна.

Энэ удаагийн захиалгат судалгаа нь залуучуудын улс төрийн оролцооны асуудлыг сонгуулийн үйл явцтай холбон төрийн бодлого, эрх зүйн орчин, залуучууд түүний дотор шинэ сонгогчийн зан үйлийг олон нийтийн санаа бодолд тулгуурлан нарийвчлан судлахыг зорилго болгов. Судалгааны ажил нь хүн амын $\frac{1}{3}$ -ийг хамарсан “залуучууд” хэмээх нийгмийн томоохон бүлгийн улс төр, сонгуулийн оролцоо, сонгуулийн зан үйлийн асуудлыг хөндсөнөөрөө онцлог юм.

Судалгаанд Монгол улсын 3 аймаг, нийслэлийн 3 дүүргийн нийт 10511 залууг хамруулсан болно. Судалгааны ажлын хүрээнд цуглуулсан мэдээллийг сонгосон арга зүйн дагуу боловсруулж, үр дүнд тулгуурлан энэхүү тайланг бичиж нийтийн хүртээл болгож байна.

Судалгааг захиалж, санхүүгийн болон техникийн дэмжлэг үзүүлж хамтран ажилласан Конрад-Аденуар-Сангийн хамт олон, судалгааны багийн зөвлөх доктор, дэд профессор С.Зульфикар, үндсэн судлаачаар ажилласан С.Ганзаяа, Б.Ганцоож, Т.Ариунболд, гэрээт судлаач нартаа болон судалгааны ажлыг үр дүнтэй гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлсэн байгууллага, хувь хүмүүст судалгааны баг чин сэтгэлийн талархал илэрхийлж байна.

1



**СУДАЛГААНЫ
АРГА ЗҮЙ, ТҮҮВЭР**

1.1. Судалгааны зорилго, зорилтууд

Монгол улсын хүн ам төдийгүй сонгогчдын ихэнхийг бүрдүүлдэг залуучуудын (18-35 насныхан) улс төр, сонгуулийн оролцоо, сонгуулийн зан үйлийг судалж, дүн шинжилгээ хийх явдал нь тус судалгааны үндсэн зорилго байлаа. Зорилгоо хэрэгжүүлэхийн тулд дараах **зорилтуудыг** дэвшүүлэн ажилласан болно. Үүнд:

- 18-35 насны залуучуудын улс төр, сонгуулийн оролцооны түвшинг тодорхойлох,
- 18-35 насны залуучуудын улс төр, сонгуулийн оролцоонд нөлөөлж байгаа хүчин зүйлст шинжилгээ хийх,
- 18-35 насны залуучууд сонгуульд хэрхэн оролцож, саналаа өгч байгааг тодорхойлох,
- 18-35 насны залуучуудын сонгуулийн зан үйлд эерэг болон сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлст дүн шинжилгээ хийх,
- Судалгааны үр дүнд тулгуурлан залуучуудын улс төр, сонгуулийн оролцоо, сонгуулийн зан үйлтэй уялдсан санал, зөвлөмж боловсруулах зэрэг орно.

1.2. Судалгааны арга зүй

Судалгааны ажлын хүрээнд баримт бичгийн контент анализ, асуулга, сурвалжлагын арга зэрэг чанарын болон тоон судалгааны аргуудыг ашигласан.

Баримт бичгийн судалгааны арга

(*баримт бичгийн контент-анализ*). Улс төрийн оролцоо, сонгогчийн зан үйлийн асуудалд холбогдох бодлого, эрх зүйн орчиныг илэрхийлэх төрийн албан ёсны баримт бичгүүд, залуучуудын чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөрүүд, иргэд, ялангуяа залуучуудын улс төрийн оролцооны талаарх онол, үзэл баримтлалыг тусгасан шинжлэх ухааны бүтээл, суурь болон хавсрага судалгааны мэдээлэл, ном, сурах бичиг, статистик эх сурвалжуудад дүн шинжилгээ хийхэд чанарын судалгааны баримт бичиг судлах аргыг голлон ашигласан болно.

Асуулгын судалгааны арга (*анкет болон анкет-сурвалжлага*). Залуучуудын улс төрийн оролцооны өнөөгийн байдал, түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг судлах үүднээс баримт бичгийн шинжилгээний үр дүн, мэдээлэлд тулгуурлан санал асуулгын хуудас боловсруулан судалгааны анхдагч мэдээлэл цуглуулж, боловсруулан үр дүнг тайланд тусгалаа.

Асуулгын бүтэц. Залуучуудын улс төр, сонгуулийн оролцоог судлах зорилгоор 5 бүлэг, 31 асуулт бүхий санал асуулгын хуудас боловсруулж, асуулгын агуулгын **эхний бүлэгт** залуучуудын улс төрийн сонирхол, оролцоо, түүний хэлбэрүүдийг (*асуулт 1-4*), **хоёрдугаар бүлэгт** залуучуудын сонгуулийн талаар ойлголт, төсөөлөл, мэдээллийн хүртээмж, сонгуулийн оролцоо, сонгуультай холбоотойгоор зохион байгуулж буй арга хэмжээний үнэлгээ, сэтгэл ханамжийг (*асуулт 5-12*), **гуравдугаар бүлэгт** сонгуулийн талаарх ерөнхий хандлага буюу өмнөх

сонгуулиудын талаарх сонгогчдын үнэлгээ, удахгүй болох сонгуулийн оролцооны төлөв, сонгогчийн зан үйл, улс төрчид, нэр дэвшигчдийн талаарх сонгогчдын хүлээлтийг (асуулт 13-17), **дөрөвдүгээр бүлэгт** улс төрийн төлөөллийн талаарх сонгогчдын үнэлгээ буюу төлөөлөгчөө таньж буй байдал, сонгогчид болон төлөөлөгчдийн эргэх холбоо, улс төрийн төлөөллийн талаарх сонгогчдын үнэлгээ, улс төр дэх залуучуудын төлөөлөл, өнгөрсөн хугацаанд зохион байгуулагдсан шат шатны сонгууль дахь залуучуудын оролцоо, оролцоог нэмэгдүүлэх талаар сонгогчдын санал бодлыг (асуулт 18-24), **тавдугаар бүлэгт** судалгаанд оролцогчийн талаарх мэдээлэл буюу оршин

суугаа газар, байршил, амьжиргааны түвшин, нас, хүйс, боловсролын түвшин, ажил эрхлэлтийн байдлын талаарх асуултуудыг (асуулт 25-31) боловсруулан мэдээлэл цуглууллаа.

Судалгааны өгөгдөл боловсруулалт.

Тоон судалгааны мэдээллийг урьдчилан бэлтгэсэн асуулгын дагуу цуглуулж, цуглуулсан мэдээллийг нийгмийн судалгааны тоон мэдээллийг боловсруулах SPSS багц программаар нэгтгэн, мэдээллийн харьцаа, харьцуулалт, корреляци, дундаж утга, хүчин зүйлийн шинжилгээ хийх зэрэг шинжилгээнүүдийг хийж үр дүнг судалгааны тайланд тусгалаа.

1.3. Судалгааны хамрах хүрээ, түүвэр

Хамрах хүрээ. Монгол улсын хэмжээнд судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг 3 бүс (баруун, төв, зүүн)-ийг төлөөлүүлэн 3 аймаг (Говь-Алтай, Хөвсгөл, Хэнтий), нийслэлийг төлөөлүүлэн 3 дүүрэг (Сонгинохайрхан, Баянгол, Баянзүрх)-ийн түвшинд зохион байгуулсан бөгөөд судалгааны эх олонлогийг Улсын бүртгэл, статистикийн газраас гаргасан хүн ам, өрхийн тооллогын 2013 оны статистик мэдээлэлд үндэслэн 18-35 насны залуучуудын тоогоор хязгаарласан. Эх олонлогийн хэмжээ 18-35 насны 1051,4 мянган залуучууд юм.

Судалгааны түүвэр.

Түүврийн үндсэн нэгж. Судалгааны түүврийн үндсэн нэгж нь залуучууд юм. “Залуучууд” гэдэгт “насны шинж байдал, нийгмийн байр суурийн онцлог зэрэг нийгмийн байгууламж, соёл, нийгэмшлийн зүй тогтол, хүмүүжлийн онцлогоос улбаалан нийгэм-сэтгэл зүйн шинж байдлаар нөхцөлдсөн цогц байдлаар адилтгаж тодорхойлогддог нийгэм, хүн ам зүйн бүлэг”-ийг ойлгоно. Мөн түүврийн анхан шатны нэгжээр аймгийн хэмжээнд сумыг, нийслэлийн хэмжээнд дүүргийг сонгосон болно.

Түүвэр олонлог. Эх олонлогийн хэмжээтэй уялдуулан түүвэр олонлогийг сонгох ерөнхий зарчимд тулгуурлан нийт эх олонлогийн 0,1 хувийг судалгаанд хамруулахаар төлөвлөсөн ба үүнээс түүвэр олонлогийн оновчтой хэмжээ буюу судалгаанд хамрагдах хүний тоо 1051 болж байгаа юм.

Хүснэгт 1. Нийслэл, орон нутгаас асуулгын судалгаанд хамрагдсан залуучуудын түүвэр олонлогийн хэмжээ, аймаг, дүүргээр

Аймаг, нийслэл	Түүвэр	Хувь
Аймаг	622	59.2
Хөвсгөл	199	18.9
Говь-Алтай	223	21.2
Хэнтий	200	19.0
Нийслэл	429	40.8
Сонгинохайрхан дүүрэг	156	14.8
Баянзүрх дүүрэг	161	15.3
Баянгол дүүрэг	112	10.7
Нийт	1051	100.1

Эх сурвалж: Улсын бүртгэл, статистикийн газар, 2013 оны статистик мэдээлэл (18-35 насны хүн ам)

2



**ЗАЛУУЧУУДЫН УЛС ТӨРИЙН
ОРОЛЦООНЫ ӨНӨӨГИЙН
БАЙДАЛД ХИЙСЭН
ШИНЖИЛГЭЭ**

2.1. Судалгаанд хамрагдсан залуучуудын хүн ам, өрхийн шинж байдал

18-35 насны залуучуудын улс төрийн оролцооны түвшин, түүнд нөлөөлж буй нийгэм-эдийн засгийн хүчин зүйлүүдийг нарийвчлан судласан үр дүнг энэ бүлэгт танилцуулж байна. Залуучуудын улс төр, сонгуулийн оролцоо, түүнд нөлөөлж буй нийгэм-эдийн засгийн хүчин зүйлийг залуучуудын хүн ам, өрхийн шинж байдал, улс төрийн оролцоо, сонгуулийн талаарх ойлголт, төсөөлөл, сонгуулийн оролцоо, зан үйл, хандлага, улс төрийн төлөөллийн талаарх үнэлгээ гэсэн таван 5 бүлэг асуудлын хүрээнд анхдагч мэдээлэл лийгцуглуулан боловсруулж, үр дүнг тайлагналаа.


Монгол улсын нийт бүс нутгийг төлөөлүүлэн орон нутгаас 3 бүсийн 3 аймаг, Улаанбаатарын 9 дүүргийг төлөөлүүлэн 3 дүүргийн нийт 1051 залууг түүвэрлэн судалгаанд хамруулсан. Судалгаанд хамрагдсан залуучуудын нийгэм, улс төрийн оролцооны нийтлэг дүр төрхийг тодорхойлох зорилгоор *хүн ам зүйн шинж байдлыг* нас, хүйс, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн байдлыг *өрхийн шинж байдалд* оршин суугаа газар, өрхийн байршил, амьжиргааны түвшингээр тус тус авч үзлээ.

Хүн ам зүйн шинж байдал



Нас: Залуучуудын насны ангилалыг 18-20 насныханы бүлэг, 21-25 насныханы бүлэг, 26-30 насныханы бүлэг, 31-35 насныханы бүлэг гэсэн дөрвөн бүлэгт хувааж үзсэн болно. Судалгаанд хамрагдсан залуучуудын 12,9 хувь нь 18-20 насныхан, 25,2 хувь нь 21-25 насныхан, 33,2 хувь нь 26-30 насныхан, 28,6 хувь нь 31-35 насныхан байна.


Зураг 1. Судалгаанд хамрагдагсдын нас





Хүйс: Судалгаанд хамрагдсан залуучуудын 52 хувь эмэгтэй, 48 хувь нь эрэгтэйчүүд байлаа.


Зураг 2. Судалгаанд хамрагдагсадын хүйс





Боловсрол: Судалгаанд хамрагдагсадын 52,0 хувь нь дээд боловсролтой, 9,0 хувь нь тусгай дунд боловсролтой, 34,3 хувь нь бүрэн дунд боловсролтой, 3,2 хувь нь суурь боловсролтой, 1,6 хувь нь албан ёсны боловсрол эзэмшээгүй болон бага боловсролтой залуучууд байна.


Зураг 3. Судалгаанд хамрагдагсадын боловсролын түвшин






Ажил эрхлэлт Судалгаанд хамрагдсан залуучуудын 31.3 хувь нь эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаанд оролцоогүй буюу ажилгүй, суралцдаг, эсвэл тэтгэмжид хамрагддаг залуучууд байлаа. Харин үлдсэн хувь нь ямар нэгэн орлого, цалинтай ажил эрхлэгчид байсан ба эдгээрээс хамгийн өндөр буюу 43.7 хувийг цалин хөлстэй ажиллагчид бүрдүүлж байна. Судалгаанд хамрагдсан залуучуудын 15.7 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 1.3 хувь нь ажил олгогчид байсан бол 4.9 хувь нь нөхөрлөл, хоршооны гишүүн, мал аж ахуй эрхлэгч, өрхийн үйлдвэрлэлд цалин хөлсгүй оролцогчид байв.

Зураг 4. Судалгаанд хамрагдагсадын ажил эрхлэлтийн байдал



Судалгаанд орон нутгаас Говь-Алтай, Хөвсгөл, Хэнтий аймгууд, нийслэлээс Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн залуучууд хамрагдсан. Судалгаанд хамрагдагсдын 59.1 хувь нь орон нутгаас, 40.9 хувь нь нийслэлд оршин сууж байна.

Зураг 5. Судалгаанд хамрагдсад аймаг, нийслэлээр




Судалгаанд хамрагдсан залуучуудыг оршин суугаа аймаг, дүүргээр нь авч үзвэл 21.2 хувь нь Говь-Алтай аймгаас, 18.9 хувь нь Хөвсгөл аймгаас, 19.0 хувь нь Хэнтий аймгаас, 10.7 хувь нь Баянгол дүүргээс, 15.3 хувь нь Баянзүрх дүүргээс, 14.8 хувь нь Сонгинохайрхан дүүрэгт оршин сууж байна.



Өрхийн байршил: Судалгаанд хамрагдсан залуучуудын 40,8 хувь нь нийслэлээс, 59,2 хувь нь орон нутагт оршин сууж байна. Өрхийн байршлын хувьд залуучуудын 27,4 хувь нь аймгийн төвөөс, 29,1 хувь нь сумын төвөөс, 2,9 хувь нь хөдөөгийн багаас хамрагдсан бол үлдсэн 40,5 хувь нь нийслэлээс хамрагдсан.


Зураг 6. Судалгаанд хамрагдагсaдын өрхийн байршил





Өрхийн амьжиргааны түвшин: Залуучуудаас өрхийн орлого амьжиргаанд нь хүрэлцэж байгаа эсэхийг тодруулахад 20,8 хувь нь тааруу, 47,5 хувь нь дунд зэрэг, 26,6 хувь нь боломжийн, 5 хувь нь хангалттай хүрэлцдэг гэж хариулсан.

Зураг 7. Судалгаанд хамрагдагсадын амьжиргааны түвшин




2.2. Залуучуудын улс төрийн оролцоо, түүний хэлбэрүүд

Залуучуудын улс төрийн оролцооны түвшин, түүний хэлбэрүүдийг судлахдаа залуучуудын улс төрийн оролцооны шинж байдал, оролцооны түвшинг харуулах гол үзүүлэлтийг: улс төрийн сонирхол, улс төрийн нөхцөл байдлын талаарх залуучуудын үнэлгээ, улс төрийн оролцооны түвшин, улс төрийн оролцооны хэлбэр гэсэн дөрвөн үзүүлэлтийн хүрээнд авч үзлээ.

Залуучуудын улс төрийн сонирхол

Судалгаанд хамрагдсан залуучуудын улс төрийн идэвх, сонирхол ямар байгааг тандахад улс төрийг маш их сонирхдог гэж 6,3 хувь нь, ер нь сонирхдог гэж 18,7 хувь нь, хааяа сонирхдог гэж 29,5 хувь нь, нэг их сонирхдоггүй гэж 33,2 хувь нь, огт сонирхдоггүй гэж 12,3 хувь нь хариулжээ.

Зураг 8. Залуучуудын улс төр сонирхох байдал



Дээрх дүнг нэгтгэж үзвэл 4 залуу тутмын 1 нь буюу 25 хувь нь улс төрийг сонирхож байгаа бол 3 залуу тутмын 1 нь буюу 29,5 хувь нь хааяа сонирхдог, 2 залуу тутмын 1 нь буюу 45,5 хувь нь улс төрийн сонирхолгүй байх хандлагатай байна.

Залуучуудын улс төрийн сонирхлыг насны бүлэгтэй нь харьцуулахад тэдний нас нэмэгдэхийн хэрээр улс төрийн сонирхол нь нэмэгдэж байгаа нь ажиглагдасан. Энэ нь насны бүлгүүдэд залуучуудын улс төрийг “Маш их сонирхдог” гэсэн хариулт 10 орчим хувиар нэмэгдэж байгаагаар батлагдаж байна. Тухайлбал, улс төрийг маш их сонирхдог гэж хариулсан залуучуудын 10,6 хувь нь 18-20 насныхан байгаа бол 40,9 хувь нь 31-35 насныхан байна.

Хүснэгт 2. Залуучуудын улс төрийн сонирхол (насны бүлгээр)

	18-20 нас	21-25 нас	26-30 нас	31-35 нас	Нийт
Маш их сонирхдог	10,6%	18,2%	30,3%	40,9%	100%
Ер нь сонирхдог	16,2%	20,8%	36,0%	26,9%	100%
Хааяа сонирхдог	13,5%	26,1%	33,9%	26,5%	100%
Нэг их сонирхдоггүй	8,9%	26,9%	33,8%	30,4%	100%
Огт сонирхдоггүй	18,6%	28,7%	27,1%	25,6%	100%
Mean¹	3,24	3,39	3,22	3,22	3,26


Залуучуудын улс төр сонирхож буй байдлыг хүйсээр харьцуулахад эрэгтэйчүүдийн 61,1 хувь нь, эмэгтэйчүүдийн 47,9 хувь нь ямар нэг байдлаар улс төрийг сонирхдог гэж хариулсан байна. Энэ нь эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдээс илүү улс төр сонирхдог болохыг харуулж байна.

¹ Тайлбар: Дундаж утга 1 рүү тэмүүлэх тусам улс төрийг сонирхох сонирхол нэмэгдэж байгаа бол 5 руу ойртоход улс төрийг сонирхох сонирхол буурч байгааг илэрхийлнэ.

Улс төрийн өнөөгийн нөхцөл байдлын талаарх залуучуудын үнэлгээ

Залуучуудаас улс төрийн өнөөгийн байдлыг хэрхэн үнэлж байгааг асуухад улс төрийн нөхцөл байдлыг хэвийн байна гэж 2,3 хувь нь, улс төрийн нөхцөл байдал хэт замбараагүй байна гэж 55,8 хувь нь, сонгууль дөхөөд шоу /улс төрийн/ хийсэн байдалтай байна гэж 27,1 хувь нь үзсэн байна. Мөн залуучуудын 10,8 хувь нь улс төрийн өнөөгийн нөхцөл байдлыг дүгнэж мэдэхгүй байна гэжээ.

Зураг 9. Залуучуудын улс төрийн өнөөгийн байдлын үнэлгээ




Залуучуудын 82,9 хувь нь өнөөгийн улс төрийн нөхцөл байдлыг хэт замбараагүй, шоу хийсэн байдалтай байна гэж үнэлжээ. Энэ нь улс төрийн нөхцөл байдлын талаар залуучууд сөрөг үнэлгээтэй байгааг харуулж байна.

Залуучуудын улс төрийн оролцооны түвшин

Улс төрийн үйл явцад оролцож байгаа байдалд дүн шинжилгээ хийхэд залуучуудын 7 хувь нь байнга буюу тогтмол оролцдог, 58 хувь нь зарим үед оролцдог, 35 хувь нь огт оролцдоггүй гэж хариулжээ. Үүнээс үзвэл залуучуудын 10 хүрэхгүй хувь улс төрийн тогтмол оролцоотой, талаас илүү буюу 2 залуу тутмын 1 нь тогтмол бус оролцоотой, 3 залуу тутмын 1 нь буюу 30 гаруй хувь нь огт оролцохгүй байна.


Зураг 10. Залуучуудын улс төрийн оролцоо



Залуучуудын улс төрийн оролцооны түвшингийн дундаж утгын коэффициентийг 1-3 гэсэн интервалаар тооцож үзэхэд 1.72 гарчээ. Дундаж утга 1 рүү ойртох тусам улс төрийн оролцоо буурах бол 3 руу ойртох тусам улс төрийн оролцоо нь нэмэгдэх юм. Үүнээс үзвэл залуучуудын улс төрийн оролцооны түвшин харьцангуй сул байгаа нь тогтоогдож байна.

Залуучуудын улс төрийн оролцоог насны бүлгээр харьцуулсан дүнг нарийвчлан авч үзвэл 26-аас дээш насныхан буюу залуучуудын улс төрийн оролцоо нас ахихын хэрээр нэмэгдэж байгаа бол улс төрийн оролцооны хувьд алдаг оног, ямар нэг байдлаар оролцогсад 21-26 насныханы дийлэнхийг эзэлж байна. Харин энэ жил анх удаа сонгуульд санал өгч оролцох залуучууд буюу 18-20 насныханы хувьд улс төрийн оролцоо хамгийн муу байгаа дүн гарчээ.

Зураг 11. Улс төрийн оролцооны түвшин, насны бүлгээр (дундаж)



Хүснэгт 3. Залуучуудын улс төрийн оролцоо, насны бүлгээр

	18-20 нас	21-25 нас	26-30 нас	31-35 нас
Байнга оролцдог	5,1%	7,2%	8,3%	7,6%
Зарим үед оролцдог	47,1%	59,6%	61,0%	56,5%
Огт оролцдоггүй	47,8%	33,2%	30,7%	35,9%
Нийт	100%	100%	100%	100%
Mean	2,43	2,26	2,22	2,28

Хүснэгт 4. Залуучуудын улс төрийн оролцоо, амьжиргааны түвшин


	Хангалттай	Боломжийн	Дунд зэрэг	Тааруу
Байнга оролцдог	7,5%	9,6%	5,6%	8,7%
Зарим үед оролцдог	52,8%	58,9%	57,9%	56,2%
Огт оролцдоггүй	39,6%	31,4%	36,5%	35,2%
Нийт	100%	100%	100%	100%
Mean	2,32	2,22	2,31	2,26

Залуучуудын хүйсээс улс төрийн оролцооны түвшин хэрхэн хамаарч байгаад статистик боловсруулалт хийхэд **корреляцын коэффициент 0.72** гарсан. Энэ нь залуучуудын улс төрийн оролцоонд хүйс **мэдэгдэхүйц нөлөөлдөг** гэсэн дүгнэлтэд хүргэж байна. Эмэгтэйчүүдийн гэр бүлийн үүрэг нь тэдний нийгэм-эдийн засгийн байр суурийг тодорхойлох шинжтэй байдаг бөгөөд улмаар улс төрийн оролцоонд ямар нэг байдлаар нөлөөлдөг.

Ажил олгогч, нөхөрлөл хоршооны гишүүдийн улс төрийн оролцоо харьцангуй өндөр буюу оролцооны дундаж утгын коэффициент нь 1.80-2.00 байна. Ажил эрхлэлтийн байдлаар тооцсон дундаж утга нь залуучуудын улс төрийн оролцооны дундаж утгаас даруй 0.20-0.30 пунктээр өндөр байна. Нийгмийн тодорхой бүлгийн ажил, амьдралд улс төрийн үйл явц нөлөөлөхийн хэрээр тэндий улс төрийн оролцоо нэмэгддэг бөгөөд энэ зүй тогтол судалгааны үр дүнгээс мөн адил ажиглагдаж байна.

Залуучуудын сонгуулийн оролцооны дундаж утга 2.62 байгаа бөгөөд энэ нь сонгуулийн ирц мэдэгдэхүйц өндөр байж болохыг илтгэж байна. Харин тэдний нийгэм -эдийн засгийн хүчин зүйлс сонгуулийн оролцоонд нь харилцан адилгүй байдлаар нөлөөлөхөөр байгаа нь судалгааны өгөгдөлд дүн шинжилгээ хийх явцад ажиглагдсан. Тухайлбал, залуучуудын боловсролын түвшин нэмэгдэхийн хэрээр сонгуулийн оролцооны дундаж утгын коэффициент 2.11 пунктээс 2.64 пункт болон нэмэгдэж байна.

Зураг 12. Сонгуулийн оролцооны дундаж утга, боловсролын түвшингээр



Улс төрийн оролцооны хэлбэр.

Улс төрийн үйл явцад ямар нэг байдлаар оролцож байгаа залуучуудаас ямар хэлбэрээр оролцож байгааг нь асуухад 6,3 хувь нь улс төрийн намын гишүүний хувиар, 8 хувь нь улс төрийн намыг идэвхтэй дэмжиж, 70,8 хувь нь сонгуульд саналаа өгч, 9,7 хувь нь УИХ, ИТХ-ын төлөөлөгчидтэй уулзаж, санал, хүсэлтээ илэрхийлж, 10,1 хувь нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан санал бодлоо хэлж, 20,2 хувь твиттер, 40,7 хувь нь фэйсбүүкээр санал бодлоо илэрхийлж оролцдог гэж хариулсан байна.

Зураг 13. Залуучуудын улс төрийн оролцооны хэлбэр



Залуучуудын улс төрийн оролцооны идэвхийг оролцооны хэлбэртэй харьцуулбал залуучуудын улс төрийн оролцооны идэвхээс үл хамааран сонгуульд саналаа өгч, нийгмийн сүлжээгээр дамжуулан санал бодлоо илэрхийлэх хандлага түлхүү байна. Харин сонгуулийн идэвх хамгийн өндөртэй буюу улс төрд байнга идэвхтэй оролцдог 5 залуу тутмын 1 нь улс төрийн намын гишүүний хувиар болон улс төрийн намыг идэвхтэй дэмжиж оролцож байгаагаар бусдаас ялгарч байна.

Хүснэгт 5. Залуучуудын улс төрийн оролцооны идэвхи, оролцооны хэлбэрүүдээр

Та улс төрд хэр зэрэг идэвхитэй оролцдог вэ?				
		Байнга оролцдог	Зарим үед оролцдог	Огт оролцдоггүй
Та ямар хэлбэрээр улс төрд оролцдог вэ?	Улс төрийн намын гишүүний хувиар оролцдог	21,8%	5,8%	3,8%
	Улс төрийн намын идэвхитэй дэмжиж оролцдог	21,8%	8,6%	4,1%
	Сонгуульд саналаа өгч оролцдог	67,9%	77,0%	61,1%
	Санал, хүсэлтээ бичгээр хүргүүлж оролцдог	14,1%	10,6%	6,8%
	Жагсаал цуглаанд оролцдог	9,0%	10,2%	5,7%
	УИХ, ИТХ-ын төлөөлөгчидтэй уулзаж санал, хүсэлтээ илэрхийлдэг	17,9%	10,6%	6,5%
	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан санал, хүсэлтээ илэрхийлдэг	7,7%	11,9%	7,6%
	Twitter-ээр санал бодлоо илэрхийлдэг	20,5%	20,7%	19,3%
	Facebook-ээр санал бодлоо илэрхийлдэг	41,0%	42,0%	38,6%
	Бусад	15,4%	11,8%	20,4%


Залуучуудын улс төрийн оролцооны үндсэн хэлбэрүүдийг насны бүлгээр нь ангилан үзвэл жагсаал цуглаанд оролцох хэлбэр, саналаа бичгээр илэрхийлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулах, твиттер, фэйсбүүкээр дамжуулан оролцох хэлбэрүүд бүх насныханы хувьд харьцангуй жигд, өндөр байна. Харин нас ахих тусам оролцооны дийлэнхи хэлбэрүүдэд оролцооны идэвх нэмэгдэх хандлага ажиглагдаж байна.

Хүснэгт 6. Залуучуудын улс төрийн оролцооны хэлбэрүүд, насны бүлгээр

Оролцооны хэлбэрүүд	Насны бүлэг				Нийт
	18-20 нас	21-25 нас	26-30 нас	31-35 нас	
Улс төрийн намын гишүүний хувиар оролцдог	12,1%	21,2%	30,3%	36,4%	100,0%
Улс төрийн намыг идэвхитэй дэмжиж оролцдог	14,3%	27,4%	29,8%	28,6%	100,0%
Сонгуульд саналаа өгч оролцдог	6,7%	23,1%	38,0%	32,1%	100,0%
Санал, хүсэлтээ бичгээр хүргүүлж оролцдог	15,0%	26,0%	34,0%	25,0%	100,0%
Жагсаал цуглаанд оролцдог	25,6%	33,3%	25,6%	15,6%	100,0%
УИХ, ИТХ-ын төлөөлөгчидтэй уулзаж санал, хүсэлтээ илэрхийлдэг	7,8%	19,6%	40,2%	32,4%	100,0%
Хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан санал бодлоо илэрхийлдэг	13,2%	22,6%	34,9%	29,2%	100,0%
Твиттерээр санал бодлоо илэрхийлдэг	9,4%	28,8%	41,0%	20,8%	100,0%
Фэйсбүүкээр санал бодлоо илэрхийлдэг	13,3%	29,2%	37,6%	19,9%	100,0%
Бусад	20,3%	29,1%	30,4%	20,3%	100,0%

Залуучуудын улс төрийн оролцооны түвшинг насны бүлгээр ангилан үзэхэд 21-30 насныханы хувьд оролцооны түвшин харьцангуй өндөр байна. Ерөнхий хандлагын хувьд мөн адил залуучуудын нас нэмэгдэхийн хэрээр улс төрийн оролцооны түвшин нэмэгдэх хандлага ажиглагдаж байна.

Зураг 14. Залуучуудын улс төрийн оролцоо, насны бүлгээр



2.3. Сонгуулийн талаарх залуучуудын ойлголт, төсөөлөл

Өнөөгийн монголын залуучуудын хувьд улс төрийн нөхцөл байдлыг, түүний дотор сонгуулийг ойлгох ойлголт, төсөөлөл нэлээд хийсвэр, улс төрийн талаарх олон нийтийн сөрөг ойлголтын суурь дээр бүрэлдэж байгаагаар онцлог юм. Залуучуудын сонгуулийн талаарх ойлголт, төсөөллийг залуучууд сонгуулийг юу гэж ойлгодог, сонгуулийн талаарх мэдээллийг авч байгаа эх сурвалж, мэдээллийн хүртээмж, сонгуулийн оролцоо болон сонгуульд оролцохгүй байгаа шалтгаан, сонгуулийн тогтолцоо, санал авах, тоолох үйл ажиллагааны зохион байгуулалтын талаарх үнэлгээ, сэтгэл ханамж гэсэн үзүүлэлтийн хүрээнд шинжилсэн.

Сонгуулийн талаарх ойлголт


Залуучууд нийгэм улс төрийн амьдралыг хэр зэрэг сонирхож байгааг судалгааны дүнгээс харвал 27,6 хувь нь үргэлж анхааран сонирхож байдаг, 59,5 хувь нь өөрт холбоотой асуудлаар зарим үед сонирхдог, 12,9 хувь огт сонирхдоггүй гэж хариулсан байна. Үүнийг улс төр, сонгуулийн талаарх залуучуудын ойлголт, төсөөлөлд суурилсан тэдний байр суурь гэж үзэж болох юм. Судалгаанд хамрагдсан залуучуудаас сонгуулийн талаарх ойлголт, төсөөллийг нь тодруулах зорилгоор орчин үеийн ардчиллын болон сонгуулийн судалгаанд өргөн ашигладаг 9 үзүүлэлтийг сонгож асуулга боловсруулан мэдээлэл авч нэгтгэлээ.

Асуулгын судалгааны дүнгээс үзэхэд судалгаанд хамрагдсан залуучуудын 28,4 хувь нь сонгууль бол иргэний улс төрийн сонголт,

6,4 хувь нь ардчилсан төрийг бүрдүүлэх арга, 5 хувь нь сонгогчдын саналыг худалдан авах үйлдэл, 15,9 хувь нь иргэдийн улс төрийн оролцооны үндсэн хэлбэр, 13,8 хувь нь сонгогчдын дуу хоолойг төрд хүргэх боломж, 7,4 хувь нь бохир аргаар төрд шургалах оролдлого, 4,1 хувь нь хууль боловсруулахад бэлтгэгдсэн улс төрчдийг сонгох сонголт, 7

хувь нь шалгарсан тэргүүний улс төрчдөөр төр бүрдүүлэх арга, 6,4 хувь нь сонгогчдыг төөрөгдүүлэх, хууран мэхлэх явуулга гэж үзжээ. Мөн залуучуудын 5,6 хувь нь бусад гэсэн хариултыг сонгосон бөгөөд ингэж хариулсан залуучуудын дунд сонгуулийг тодорхойлж мэдэхгүй, ойлгохыг хүсдэггүй гэсэн хандлага ажиглагдаж байна.

Зураг 15. Сонгуулийн талаарх залуучуудын ойлголт, төсөөлөл




Сонгуулийн талаарх ойлголт, төсөөлөл, боловсролоор

Харин сонгуулийн талаарх эерэг ойлголт (сонгогчдын дуу хоолойг төрд хүргэх боломж, хууль боловсруулахад бэлтгэгдсэн улс төрчдийг сонгох сонголт, шалгарсан тэргүүний улс төрчдөөр төр бариулах арга) суурь боловсролтой залуучуудын хувьд түлхүү байсан бол сонгуулийн талаар сөрөг ойлголттой (сонгогчдын саналыг худалдаж авах үйлдэл, бохир аргаар төрд шургалах оролдлого, сонгогчдыг төөрөгдүүлэх, хууран мэхлэх явуулга), итгэл алдарсан иргэд нь бага боловсролтой залуучуудын дунд жин дарсан дүн гарсан.

Хүснэгт 7. Сонгуулийн талаарх залуучуудын ойлголт, төсөөлөл (боловсролоор)

	Албан ёсны боловсрол эзэмшээгүй	Бага боловсролтой	Суурь боловсролтой	Бүрэн дунд боловсролтой	Тусгай дунд боловсролтой	Дээд боловсролтой
Иргэний улс төрийн сонголт	28,6	33,3	23,5	28,6	31,6	27,8
Ардчилсан төрийг бүрдүүлэх арга	-	-	14,7	6,9	6,3	5,7
Иргэний улс төрийн оролцооны үндсэн хэлбэр	-	-	14,7	13,6	13,7	18,3
Зөв ойлголт /Нийт	28,6	33,3	52,9	49,1	51,6	51,8
Сонгогчдын дуу хоолойг төрд хүргэх боломж	14,3	22,2	2,9	13,1	10,5	15,4
Хууль боловсруулахад бэлтгэгдсэн улс төрчдийг сонгох сонголт		-	14,7	3,6	4,2	3,5
Шалгарсан, тэргүүний улс төрчдөөр төр бариулах арга	14,3	-	17,6	8,1	3,2	6,4
Эерэг ойлголт/Нийт	57,2	22,2	35,2	24,8	17,9	25,3
Сонгогчдын саналыг худалдаж авах үйлдэл	-	-	5,9	6,1	4,2	4,6
Бохир аргаар төрд шургалах оролдлого	-	11,1	2,9	5,8	14,7	7,5
Сонгогчдыг төөрөгдүүлэх, хууран мэхлэх явуулга	-	22,2	-	7,5	7,4	5,7
Сөрөг ойлголт/Нийт	0	33,3	2,9	13,3	22,1	13,2
Бусад	14,3	11,1	2,9	6,7	4,2	5,1
Нийт	100	100	100	100	100	100


Зураг 16. Сонгуулийн талаарх залуучуудын ойлголт, насны бүлгээр



Улс төр, сонгуулийн талаарх мэдээлэл, түүний хүртээмж.

Залуучуудаас мэдээллийн ямар эх сурвалжаас улс төр, сонгуулийн талаарх мэдээлэл авч байгааг нь тодруулахад 78,9 хувь нь телевизээс, 19,2 хувь нь сониноос, 8,8 хувь нь сэтгүүлээс, 28,3 хувь нь сонгуулийн сурталчилгааны материалаас, 7,6 хувь нь радио, FM-ээс, 13,9 хувь нь мэдээллийн вэб сайтуудаас, 29,5 хувь нь фэйсбүүкээс, 5 хувь твиттерээс, 3,2 хувь нь гар утасны мессежээс, 11,6 хувь нь нэр дэвшигчдийн сонгогчтой хийсэн уулзалтаас, 10,7 хувь нь сонгуулийн тойрог, хэсгийн хорооны мэдээллээс, 3,6 хувь нь нэр дэвшигчдийн сонгуулийн штабаас, 8,7 хувь нь бусдын ам дамжсан ярианаас, 8,8 хувь нь гэр бүл, ойр дотныхоо хүнээс, 17,7 хувь нь сурталчилгааны самбараас, 1,8 хувь нь бусад мэдээллийн эх сурвалжаас олж авдаг гэж хариулсан.

Зураг 17. Залуучууд сонгуулийн талаарх мэдээлэл авч буй эх сурвалж



Залуучууд сонгуулийн талаарх мэдээлэл авч байгаа эх сурвалжийг өрхийн байршлаар нь харьцуулан судлахад уламжлалт мэдээллийн хэрэгсэл, тэр дундаа телевизээс мэдээлэл авах байдал Улаанбаатар хотод илүү байгаа ч сонингоос мэдээлэл авах байдал нь аймгийн төвд өндөр байна. Харин орчин үеийн мэдээллийн хэрэгсэл болох мэдээллийн вэб сайт, фэйсбүүк, твиттер зэргээс Улаанбаатар хотын залуучууд илүүтэй мэдээлэл авч байгаа нь харагдаж байгаа ч аймгийн төв болон сумын төвийн залуучуудын дунд фэйсбүүкийн хэрэглээ өндөр байгааг анзаарууштай юм.


Тэгвэл цаг үеийн шинжтэй, сонгуулийн үеэрх мэдээллийн эх сурвалжийн нэг хэлбэр болох нэр дэвшигчдийн уулзалтаас хөдөөгийн багийн болон сумын төвийн залуучууд илүүтэй мэдээлэл авдаг бол сонгуулийн тойрог, хэсгийн хорооны мэдээлэлд Улаанбаатар хотын залуучууд илүүтэй ач холбогдол өгдөг байна.

Хүснэгт 8. Залуучууд сонгуулийн талаарх мэдээлэл авч буй эх сурвалж, өрхийн байршлаар

	Нийслэл	Аймгийн төв	Сумын төв	Хөдөөгийн баг
Сонин	18,1%	23,3%	18,3%	6,5%
Сэтгүүл	9,6%	8,0%	8,2%	9,7%
Телевиз	83,1%	77,8%	74,2%	77,4%
Радио, FM	11,0%	5,6%	4,2%	12,9%
Мэдээллийн веб сайт	18,8%	12,5%	9,2%	6,5%
Facebook	35,2%	28,5%	24,5%	9,7%
Twitter	7,3%	4,5%	2,9%	-
Нэр дэвшигчтэй хийсэн уулзалт	3,5%	12,8%	19,9%	29,0%
Сонгуулийн тойрог, хэсгийн хорооны мэдээлэл	14,3%	9,4%	7,8%	-
Нэр дэвшигчдийн сонгуулийг штабаас	2,3%	4,5%	4,6%	3,2%
Бусдын ам дамжсан ярианаас	8,5%	11,1%	6,9%	6,5%
Гэр бүл, ойр дотныхноос	8,9%	10,4%	7,5%	6,5%
Сурталчилгааны самбараас	30,3%	11,1%	7,2%	9,7%
Сонгуулийн сурталчилгааны материал	22,1%	32,6%	33,3%	22,6%
Гар утасны мессэж	3,8%	2,1%	2,9%	9,7%
Бусад	1,9%	1,4%	2,0%	3,2%

Судалгааны хүрээнд сонгуулийн талаарх мэдээлэл, сурталчилгааг олон нийтэд хэр хүртээмжтэй байгааг үнэлүүлэхэд 17,3 хувь нь их хүртээмжтэй, 44,3 хувь нь ер нь хүртээмжтэй, 24,2 хувь нь хүртээмж муутай, 3,9 хувь нь огт хүртээмжгүй, 10,3 хувь нь мэдэхгүй гэж үнэлсэн байна.

Зураг 18. Сонгуулийн талаарх мэдээлэл, сурталчилгааны олон нийтэд хүртээмжтэй байдал




Судалгаанд хамрагдсан залуучуудын 61,6 хувь нь сонгуулийн талаарх мэдээллийн хүртээмжийг их буюу ер нь хүртээмжтэй гэсэн бол 28,1 хувь нь хүртээмж муутай, огт хүртээмжгүй гэж үзсэн байна.

2.4. Сонгуулийн оролцоо, зан үйл, хандлага

Залуучуудын сонгуулийн оролцоо. Сүүлийн жилүүдийн сонгуулийн оролцооны статистикаас харахад залуучуудын сонгуульд оролцох оролцоо хүн амын бусад бүлгээс харьцангуй доогуур байна. Тухайлбал, 2012 оны УИХ сонгуулийн ирц 65 орчим хувьтай байсан бол 18-35 насын залуучуудын 41 хувьтай байжээ. Энэ асуудлыг илүү нарийвчлан судалж, залуучуудын оролцооны түвшин, сонгуульд оролцохгүй байгаа шалтгаан, нөлөөлж буй хүчин зүйл зэрэгт дүн шинжилгээ хийлээ.

Зураг 19. Залуучуудын сонгуулийн оролцоо




Залуучуудаас сонгуульд оролцож байгаа эсэхийг нь асуухад судалгаанд хамрагдсан залуучуудын 78 хувь нь ямар нэгэн байдлаар сонгуульд оролцож саналаа өгч байсан бол 22 хувь нь сонгуульд оролцож санал өгч байгаагүй залуучууд байлаа (Зураг 20-оос үзнэ үү).

Залуучуудын улс төрд оролцохгүй байх шалтгаан

Судалгаанд хамрагдсан залуучуудын 20.9 хувь нь итгэл хүлээсэн нам, улс төрч байхгүй, 17.9 хувь нь сонгуульд санал өгөх насанд хүээргүй байсан, 13.7 хувь нь улс төрд итгэдэггүй, 11.5 хувь нь улс төр сонирхдоггүй гэсэн үндэслэлийг улс төрд оролцохгүй байх шалтгаан болгон хариулжээ.

Зураг 20. Улс төрд оролцохгүй байх шалтгаан






Сонгуульд саналаа өгч оролцож байгаагүй залуучуудын **17,9** хувь нь сонгуулийн насанд хүрээгүйн улмаас өнгөрсөн хугацаанд зохион байгуулагдсан сонгуулиудад оролцож байгаагүй байна. Харин үлдсэн **80** гаруй хувь нь сонгуулийн насанд хүрсэн хэдий ч сонгуульд орцохгүй байхад нь дараах зүйлүүдийг тодорхой хэмжээгээр нөлөөлсөн гэж үзжээ. Залуучуудын сонгуульд

оролцохгүй байхад хамгийн их нөлөөлж байгаа зүйлүүд нь итгэл хүлээсэн нам, улс төрч байхгүй, улс төрд итгэдэггүй, улс төр сонирхдоггүй байдлууд гэж үзэж байна. Эндээс үзвэл залуучуудын сонгуульд оролцохгүй байх шалтгаан нь улс төрд итгэх итгэл, улс төр сонирхох байдлаас илүү хамаарч байгаа нь ажиглагдаж байна.

Сонгуулийн одоогийн/холимог/ тогтолцооны талаарх залуучуудын үнэлгээ


Одоогийн сонгуулийн (холимог) тогтолцоог залуучуудаар үнэлүүлэхэд тэдний 11 хувь нь холимог тогтолцоог илүү оновчтой, цаашид энэ тогтолцоогоороо явах нь зөв гэж үзсэн бол 51 хувь нь оновчгүй, сонгуулийн тогтолцоог одоогийнхоос илүү оновчтой болгох шаардлагатай гэж үзжээ. Үлдсэн 38 хувь нь өнөөгийн сонгуулийгн тогтолцоог үнэлж мэдэхгүй буюу тус асуултанд хариулаагүй байна.

Зураг 21. Сонгуулийн одоогийн /холимог/ тогтолцооны талаарх залуучуудын үнэлгээ



Сонгуулийн санал авах үйл ажиллагаа сонгогчдод чирэгдэлгүй, үр дүнтэй зохион байгуулагдаж байгаа эсэхийг тодруулахад 21,6 хувь нь чадаж байна, 40,4 хувь нь сайжруулах шаардлагатай, 21,3 хувь нь чадахгүй байна гэж үзсэн бол үлдсэн 16,7 хувь нь тухайн асуултанд хариулж мэдэхгүй буюу сонгуулийн санал авах үйл ажиллагааг үнэлж мэдэхгүй байна гэжээ.


Зураг 22. Сонгуулийн санал авах үйл ажиллагаа сонгогчдод чирэгдэлгүй, үр дүнтэй зохион байгуулагдаж чадаж байгаа эсэх талаарх залуучуудын үнэлгээ



Залуучуудын 60 гаруй хувь нь сонгуулийн санал авах үйл ажиллагааг сонгогчдод чирэгдэлгүй, үр дүнтэй зохион байгуулагдаж чадахгүй байна, цаашид илүү боловсронгуй болгож сайжруулах шаардлагатай гэж үзсэн нь тухайн асуудалд анхаарал хандуулах шаардлагатай байгааг илтгэж байна.

Сонгуулийн санал авах үйл ажиллагааны талаарх залуучуудын сэтгэл ханамж ямар байгааг тодруулахад судалгаанд хамрагдсан залуучуудын 5 хувь нь сэтгэл ханамж өндөр, 35 хувь нь ер нь сэтгэл ханамжтай, 37 хувь нь сэтгэл ханамжгүй, 23 хувь нь хэлж мэдэхгүй гэж хариулсан.

Зураг 23. Сонгуулийн санал авах үйл ажиллагааны талаарх залуучуудын сэтгэл ханамж




Залуучуудын 40 хувь нь сонгуулийн санал авах үйл ажиллагаанд сэтгэл ханамжтай байгаа бол мөн 40 орчим хувь нь тус үйл ажиллагаанд сэтгэл ханамжгүй, үлдсэн 20 гаруй хувь нь сонгуулийн санал авах үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжаа илэрхийлж мэдэхгүй байна.

Өнгөрсөн сонгуулиудын талаарх залуучуудын үнэлгээ

Өмнө нь болж өнгөрсөн шат шатны сонгуулийн талаар залуучууд ямар үнэлэлттэй байгааг тодруулахад 7,4 хувь нь шударга, хараат бус, чөлөөт сонгууль болсон, 42,3 хувь нь зарим нь шударга, зарим нь шударга бус сонгууль болсон, 31,3 хувь нь шударга бус, сонгогчдын саналыг будилаантуулсан сонгууль болсон гэж хариулжээ. Мөн тус асуултанд судалгаанд оролцсон залуучуудын 18,9 хувь хариулж мэдэхгүй байна.


Зураг 24. Өнгөрсөн сонгуулиудын талаарх залуучуудын үнэлгээ



Сонгуулийн санал авах, тоолох үйл ажиллагаанд итгэж буй байдал

Судалгаанд хамрагдсан залуучуудын 14 хувь нь тус үйл ажиллагаанд бүрэн итгэлтэй, 53 хувь нь ер нь эргэлзээтэй, 20 хувь нь огт итгэлгүй, 13 хувь нь хэлж мэдэхгүй гэж хариулжээ.

Зураг 25. Сонгуулийн санал авах, тоолох үйл ажиллагаанд итгэж буй байдал




Залуучуудын 70 гаруй хувь нь ер нь эргэлзээтэй, огт итгэлгүй гэж хариулсан нь анхаарал татаж байгаа юм. Сонгуулийн санал авах, тоолох үйл ажиллагаанд залуучуудын ойролцоогоор $\frac{3}{4}$ нь итгэхгүй байна.

УИХ-ын 2016 оны ээлжит сонгуульд залуучуудын оролцооны төлөв


Залуучуудын сонгуулийн оролцооны төлвийг тандах зорилгоор удахгүй зохион байгуулагдах 2016 оны Улсын Их Хурлын сонгуульд оролцох бодолтой байгаа эсэхийг тодрууллаа. Ингэхэд тус асуултанд судалгаанд хамрагдагсадын 71 хувь нь оролцоно, 9 хувь нь оролцохгүй, 14 хувь нь одоогоор шийдээгүй, 6 хувь нь хэлж мэдэхгүй байна гэж хариулсан байна. Залуучуудын тус асуултанд хариулсан байдлаас үзэхэд 2016 оны УИХ-ын сонгуульд залуучуудын дийлэнх нь оролцох төлөв ажиглагдаж байна.

Зураг 26. УИХ-ын 2016 оны ээлжит сонгуульд залуучууд оролцох эсэх



Залуучуудын сонгуулийн оролцооны дундаж утга 2.62 байгаа бөгөөд энэ нь сонгуулийн ирц мэдэгдэхүйц өндөр байж болохыг илтгэн харуулж байна. Харин тэдний нийгэм - эдийн засгийн хүчин зүйлс сонгуулийн оролцоонд нь харилцан адилгүй байдлаар нөлөөлөхөөр байгаа нь судалгааны өгөгдөлд дүн шинжилгээ хийх явцад ажиглагдаж байгаа болно. Тухайлбал, залуучуудын боловсролын түвшин нэмэгдэхийн хэрээр тэдний сонгуулийн оролцоо бага багаар нэмэгдэх зүй тогтол ажиглагдсан. Өөрөөр хэлбэл боловсролын түвшин нэмэгдэхийн хэрээр сонгуулийн оролцооны дундаж утгын коэффициент 2.11 пунктээс 2.64 пункт болон нэмэгдсэн.

Зураг 27. Сонгуулийн оролцооны дундаж утга (боловсролын түвшингээр)



Өмнө болж өнгөрсөн сонгуулиудын талаарх залуучуудын үнэлгээ нь 2016 оны УИХ, ИТХ-ын сонгуулийн ирцэд тодорхой хэмжээнд нөлөөлж байна. Залуучуудын өмнөх сонгуулиудад өгсөн үнэлгээ нь эерэг тийшээ хандах тусмаа 2016 оны сонгуульд оролцох байдал нэмэгдэж байгаа бол сонгуульд саналаа өгч оролцохоо одоогоор шийдээгүй, хэлж мэдэхгүй байгаа иргэдийн жин өмнөх сонгуулиудад сөрөг үнэлгээ өгч байсан иргэдийн дунд илүүтэй жин дарж байна.

Хүснэгт 9. Өнгөрсөн сонгуулиуд өгсөн үнэлгээ нь залуучуудын 2016 оны сонгуулийн идэвхид нөлөөлж буй байдал

2016 оны сонгуульд оролцож саналаа өгөх үү?						
		Тийм	Үгүй	Одоогоор шийдээгүй байна	Хэлж мэдэхгүй байна	Нийт
Өмнө нь болж өнгөрсөн сонгуулиудыг Та хэрхэн үнэлж байна вэ?	Шударга, хараат бус, чөлөөт сонгууль болсон	84,6	9,0	2,6	3,8	100
	Зарим нь шударга, зарим нь шударга бус болсон	77,5	6,5	13,5	2,5	100
	Шударга бус, сонгогчдын саналыг будилуулсан сонгууль болсон	63,5	14,0	17,3	5,2	100
	Хариулж мэдэхгүй байна	63,8	9,5	12,6	14,1	100

2016 оны сонгуульд саналаа өгч оролцоно /71,3 хувь/ гэж хариулсан залуучуудын 49.3 хувь нь 2012 оны сонгуульд оролцож байсан, энэ удаад ч сонгуульд идэвхитэй байр сууринаас оролцох залуучууд байгаа бол 19.1 хувь нь өмнөх сонгуульд санал өгч байгаагүй залуучууд байна.


Сонгогчийн зан үйл

Сонгогчийн зан үйлийн тухай сэдэв бол манайд харьцангуй бага судлагдсан асуудлын нэг юм. Гэхдээ онол, үзэл баримтлалын ерөнхий агуулга, өмнө хийгдсэн судалгааны мэдээлэлд тулгуурлан зан үйлийг тодруулахдаа сонгогчдын сонголт хийхдээ үндэс болгож байгаа гол шалгуур үзүүлэлтүүд, урт болон богино хугацааны хүчин зүйл, өөрийн ахуй амьдралтай холбогдох хүчин зүйлүүдийг хэрхэн тооцдогийг тодруулах оролдлого хийлээ. Ингэхдээ сонгогчийн хувийн зан үйл, ёс суртахуун, боловсрол, мэдлэг хандлага зэрэг хүчин зүйлсийг чухалчилж үзлээ.

Залуу сонгогчийн зан үйлийг судлах зорилгоор судалгаанд хамрагдсан залуучуудаас сонгуульд оролцож саналаа өгөхдөө юуг чухалчлан үзэж сонголтоо хийж

байгааг нь тодруулсан. Залуучуудын 4,2 хувь нь улс төрийн намыг чухалчилдаг, 22,6 хувь зөвхөн нэр дэвшигчийг чухалчилдаг, 9,5 хувь нь зөвхөн намын мөрийн хөтөлбөрийг чухалчилдаг, 16,7 хувь нь дээрх бүгд (нам, нэр дэвшигч, мөрийн хөтөлбөр)-ийг чухалчилдаг, 5,4 хувь нь дэмжиж буй намаас хэн нэр дэвшиж байгааг чухалчилдаг, 2,6 хувь нь дэмжиж буй нэр дэвшигч нь аль намаас нэр дэвшиж байгааг чухалчилдаг, 1,3 хувь нь сонгуулийн сурталчилгааг чухалчилдаг, 4,4 хувь нь гэр бүл, ойр дотныхоо хүмүүсийн саналыг чухалчилж үздэг, 26,6 хувь нь сонгуулийн өмнөх жилүүдэд улс төрийн нөхцөл байдлыг ажиглаж, дүгнэсний үндсэн дээр сонголтоо хийдэг гэж хариулсан байна. Мөн тэдний 6,7 хувь нь дээр дурдагдсанаас бусад зүйлийг чухалчилдаг гэжээ.

Зураг 28. Залуучууд сонгуульд оролцож саналаа өгөхдөө чухалчилж буй зүйлс



Залуучууд сонгуульд оролцож саналаа өгөхдөө чухалчилж буй зүйлүүдийг харуулсан дээрх зургаас тэд саналаа өгөхдөө хамгийн их чухалчилж буй дараах 3 зүйлийг харж болохоор байна. Үүнд *нэгдүгээрт*, сонгуулийн өмнөх жилүүдэд улс төрийн нөхцөл байдлыг ажиглаж, дүгнэсний үндсэн дээр саналаа өгөх, *хоёрдугаарт*, нэр дэвшигч хэн байгааг харж саналаа өгөх, *гуравдугаарт*, нам, нэр дэвшигч, мөрийн хөтөлбөрийг харж дүгнэсний үндсэн дээр саналаа өгөх гэсэн хандлагууд давамгайлж байна. Сонгуулийн сурталчилгаа, улс төрийн нам, дэмжиж буй намаас хэн нэр дэвшиж байгаа, дэмжиж буй нэр дэвшигч нь аль намаас нэр дэвшигч байгаа, гэр бүл, ойр дотны хүмүүсийн сонголтыг залуучууд төдийлөн чухалчилж үзэхгүй байна. Өөрөөр хэлбэл залуучуудын дунд саналаа өгөхдөө улс төрийн нөхцөл байдал, нэр дэвшигч, нам, нэр дэвшигч, мөрийн хөтөлбөрийг үнэлж дүгнэсний үндсэн дээр ухамсартайгаар өөрийн бие даасан шийдвэр гаргаж сонголтоо хийх хандлага өндөр байна.

Өнгөрсөн хугацаанд баримталж ирсэн сонгуулийн (холимог) тогтолцоонд хандаж байсан байр суурь нь сонгогчийн зан үйлтэй

хамааралтай байгаа эсэхийг шинжилж үзэхэд сонгуулийн холимог тогтолцоог оновчтой, сонгууль энэ тогтолцоогоороо явах нь зөв гэж үзэж байсан залуучуудын дийлэнх нь урт болон богино хугацааны хүчин зүйл болох нам, нэр дэвшигч, мөрийн хөтөлбөр зэргийг чухалчилж байсан бол сонгуулийн холимог тогтолцоог оновчгүй, одоогийнхоос илүү оновчтой болгох шаардлагатай гэж үзэж байсан иргэдийн хувьд богино хугацааны хүчин зүйл болох сонгуулийн өмнөх жилүүдэд улс төрийн нөхцөл байдлыг ажиглаж дүгнэсний үндсэн дээр, зөвхөн нэр дэвшигчийг чухалчилж сонгуульд саналаа өгөхөө илэрхийлжээ.

Харин сонгуулийн холимог тогтолцоог оновчтой эсэхэд хариулж мэдэхгүй байсан иргэдийн тухайд сонгуулийн өмнөх жилүүдэд улс төрийн нөхцөл байдлыг ажиглаж, дүгнэсний үндсэн дээр сонгуульд саналаа өгнө гэсэн байр суурь илэрхийлсэн болно.


Хүснэгт 10. Сонгуулийн тогтолцооны талаарх залуучуудын байр суурь, сонгогчдын зан үйлийн хамаарал

Та одоогийн сонгуулийн (холимог) тогтолцоог оновчтой гэж үздэг үү?				
		Оновчтой, сонгууль энэ тогтолцоогоороо явах нь зөв	Оновчгүй, одоогийнхоос илүү оновчтой болгох шаардлагатай	Хариулж мэдэхгүй байна
Урт хугацааны	Зөвхөн улс төрийн нам	6,6%	4,1%	3,5%
	Дэмжиж буй намаас хэн нэр дэвшиж байгааг	5,8%	4,7%	6,3%
	Дэмжиж буй нэр дэвшигч нь аль намаас нэр дэвшиж байгааг	1,7%	3,2%	2,0%
	Гэр бүл ойр дотныхоны сонголтыг чухалчилдаг	5,8%	2,6%	6,3%
Богино хугацааны	Зөвхөн нэр дэвшигч	21,5%	25,3%	19,4%
	Зөвхөн намын мөрийн хөтөлбөр	10,7%	9,9%	8,6%
	Сонгуулийн сурталчилгааг чухалчилдаг	-	0,9%	2,3%
	Сонгуулийн өмнөх жилүүдэд УТ-ийн нөхцөл байдлыг ажиглаж, дүгнэсний үндсэн дээр	22,3%	25,5%	29,5%
Урт болон богино хугацааны	Дээрх бүгд/ нам, нэр дэвшигч, мөрийн хөтөлбөр/	24,0%	18,4%	12,1%
	Бусад	1,7%	5,4%	9,8%
Нийт		100%	100%	100%

Ард түмнийг төлөөлөн төрд ажиллахаар сонгуульд нэр дэвшиж байгаа хүний талаар ямар хүлээлттэй байгааг залуучуудаас тодруулахад 7,7 хувь нь хуучин сонгогдож байсан туршлагатай улс төрч, 48,2 хувь нь хэлсэн үгэндээ эзэн болдог хүн, 18,6 хувь нь шинэ, залуу хүн, 5,7 хувь нь бэл бэнчинтэй, идэж уухааргүй хүн, 31,0 хувь нь тойрогтоо тодорхой юм хийж чадахаар хүн, 4,4 хувь нь нутаг усны хүн, 1 хувь нь гадаад имиж сайтай хүн, 3,6 хувь нь олонд танигдсан, нэр хүнтэй хүн байх, 35,7 хувь нь боловсрол

мэдлэгээрээ сонгогчдын итгэл, дэмжлэгийг хүлээсэн хүн, 7,5 хувь нь ноён нуруутай хүн, 12,9 хувь нь шийдэмгий зоригтой хүн, 31,4 хувь нь хариуцлага хүлээх чадвартай хүн, 2,9 хувь нь намдаа тууштай үнэнч хүн, 18 хувь нь үзэл бодол, байр суурь нь тодорхой хүн байх, 20,7 хувь нь улс төрийн соёл, ёс зүйтэй хүн байх ёстой гэсэн хүлээлттэй байна. Харин 4,4 хувь нь нэр дэвшиж буй хүний талаар өөр хүлээлттэй байна гэж хариулжээ.

Зураг 29. Сонгуульд нэр дэвшиж буй хүний талаарх залуучуудын хүлээлт



2.5. Улс төрийн төлөөллийн талаарх залуучуудын үнэлгээ


Манай улсын улс төрийн тогтолцооны өнөөгийн нөхцөлд иргэдийн эрх мэдэл хэрэгжүүлэх, шийдвэр гаргах түвшиний институтийн төлөөллийг иргэдийн улс төрийн төлөөлөл гэж үзэж болно. Үүний гол шалтаан нь манай нийгмийн улс төрийн харилцаа, сонгуулийн үйл явцад улс төрийн намууд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэгтэй холбоотой юм.

Залуучууд улс төрийн төлөөллийн талаар ямар үнэлгээтэй байгааг тандах зорилгоор судалгаанд хамрагдсан залуучуудаас дараах асуудлуудыг тодруулсан. Залуучуудаас өөрсдийгөө төлөөлөн ажиллаж буй төлөөлөгчдөө мэдэж байгаа эсэх, төлөөлөгч сонгогчтойгоо эргэх холбоотой ажиллаж байгаа эсэх, тойргоосоо сонгосон

төлөөлөгчдийн төлөөллийн талаарх үнэлгээ, Монгол Улсын Их Хурал, Орон нутгийн ИТХ-ын байгууллагуудад залуучуудын төлөөлөл хангагдаж байгаа талаар ямар үнэлгээтэй байгааг нь асуулаа.

Залуучуудын 58,6 хувь нь тойргоосоо сонгогдсон УИХ-ын гишүүнийг, 41,2 хувь нь орон нутгийнхаа ИТХ-ын төлөөлөгчийг мэдэж байна. Залуучуудын 58,8 хувь нь оршин суугаа тойргоосоо сонгогдсон ИТХ-ын төлөөлөгчийг танихгүй, мэдэхгүй байгаа бол 41,4 хувь нь өөрийн тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүний талаар мэдэхгүй байна. Тэдний УИХ-ын гишүүнийг мэдэж байгаа байдал нь ИТХ-ын төлөөлөгчөө мэдэж байгаа байдлаас 17,4 хувиар илүү байна.


Зураг 30. Тойргоосоо сонгогдсон төлөөлөгчдийг мэдэж буй байдал



Судалгаанд хамрагдсан залуучууд тойргоосоо сонгогдсон төлөөлөгчдийн өөрийгөө /залуучууд/ төлөөлөн ажиллаж байгаа байдлыг дараах байдлаар үнэлжээ. Тойргоосоо сонгогдсон УИХ-ын гишүүний төлөөллийг залуучуудын 5,9 хувь нь төлөөлөн ажиллаж чадаж байна. 19,0 хувь нь зарим үед төлөөлөн ажиллаж чаддаг, 41,0 хувь нь төлөөлөн ажиллаж чаддаггүй гэж үнэлсэн бол үлдсэн 34,1 хувь УИХ-ын гишүүний төлөөллийн талаар үнэлгээ өгч мэдэхгүй байна гэжээ.


Тухайн тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүдээ мэдэж байгаа байдал нь орон нутагт Улаанбаатар хотоос илүү байна. Өөрөөр хэлбэл Улаанбаатар хотын залуучуудын 42,5 хувь нь өөрийн тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүнээ мэдэж байгаа бол орон нутагт амьдардаг залуучуудын 60-70 хувь нь мэднэ гэж хариулжээ.

Зураг 31. Тойргоосоо сонгогдсон төлөөлөгчдийг мэдэж буй байдал /өрхийн байршлаар/ хувиар




Тойргоосоо сонгогдсон УИХ-ын гишүүн болон ИТХ-ын төлөөлөгчдөө мэдэж байгаа эсэхийг насны бүлгээр харьцуулбал залуучуудын нас нэмэгдэхийн хэрээр өөрийн тойргоос сонгогдсон улс төрийн албан хаагчдаа таних байдал нэмэгдэж байна.

Зураг 32. Тойргоосоо сонгогдсон төлөөлөгчдийг мэдэж буй байдал (насны бүлгээр)



Залуучуудын 3,9 хувь нь оршин суугаа тойргоосоо сонгогдсон ИТХ-ын төлөөлөгчөө залуучуудыг төлөөлөн ажиллаж чаддаг, 18,1 хувь нь зарим үед төлөөлж ажиллаж чаддаг, 38,5 хувь нь төлөөлөн ажиллаж чаддаггүй гэж үнэлсэн бол 39,5 хувь нь ИТХ-ын төлөөлөгчийнхөө өөрийгөө төлөөлөн ажиллаж байгаа эсэхэд үнэлгээ өгч мэдэхгүй байна.

Зураг 33. Тойргоос сонгогдсон төлөөлөгчдийн талаарх залуучуудын үнэлгээ




Залуучуудын 40 орчим хувь нь тойргоосоо сонгогдсон УИХ-ын гишүүн, ИТХ-ын төлөөлөгчийг сонгогчдоо төлөөлөн ажиллаж чадахгүй байна гэж үнэлсэн бол мөн 34,1-39,5 хувь нь тэдний төлөөллийн талаар үнэлгээ өгч мэдэхгүй байна. Залуучуудын 22-26 хувь нь буюу $\frac{1}{4}$ нь л УИХ-ын гишүүн, ИТХ-ын төлөөлөгчөө тогтмол болон зарим үед төлөөлөн ажиллаж чадаж байна гэж үнэлжээ. Дээрхээс харахад залуучуудын оршин суугаа тойргоосоо сонгогдсон төлөөлөгчдийнхөө төлөөллийн талаарх үнэлгээ нь хангалтгүй, төлөөлөгчдийнхөө өөрийгөө төлөөлөн ажиллаж чадаж байгаа эсэхэд үнэлгээ өгч чадахгүй байна. Харин үнэлгээнээс харахад УИХ-ын гишүүн болон ИТХ-ын төлөөлөгчдөд өгсөн үнэлгээ хооронд хүчтэй ялгаа ажиглагдахгүй байна.

Залуучууд тойргоос сонгогдсон төлөөлөгчдийнхөө сонгогчидтойгоо эргэх холбоотой ажиллаж байгааг дараах байдлаар үнэлсэн байна. Судалгаанд хамрагдсан залуучуудын 4,9 хувь нь ИТХ-ын төлөөлөгчөө сонгогчидтойгоо байнга эргэх холбоотой ажилладаг, 22,4 хувь нь зарим үед л холбоотой ажилладаг, 30,2 хувь нь холбоотой ажилладаггүй гэж үнэлсэн бол 42,6 хувь нь төлөөлөгчийнхөө эргэх холбоотой ажиллаж байгаа эсэхийг мэдэхгүй байна.

Харин тойргоосоо сонгогдсон УИХ-ын гишүүний сонгогчидтойгоо эргэх холбоотой ажиллаж байгааг үнэлсэн асуултанд 5,2 хувь нь байнга эргэх холбоотой ажилладаг, 28,7 хувь нь зарим үед л холбоотой ажилладаг, 30,5 хувь нь холбоотой ажилладаггүй, 35,5 хувь нь энэ талаар мэдэхгүй гэж хариулжээ.


Зураг 34. Тойргоос сонгогдсон төлөөлөгч сонгогчидтойгоо эргэх холбоотой ажиллаж чадаж байна уу?



Тойргоосоо сонгогдсон УИХ-ын гишүүнийг судалгаанд оролцсон залуучуудын 4,0 хувь нь маш сайн, 12,9 хувь нь сайн, 36,6 хувь нь дунд, 24 хувь нь муу, 22,5 хувь нь мэдэхгүй гэж үнэлсэн байна. Тойргоосоо сонгогдсон

ИТХ-ын төлөөлөгчийг судалгаанд оролцсон залуучуудын 2,9 хувь нь маш сайн, 12,5 хувь нь сайн, 28,9 хувь нь дунд, 25,7 хувь нь муу, 30 хувь нь мэдэхгүй гэж үнэлжээ.


Зураг 35. Тойргоос сонгогдсон төлөөлөгчдийн талаарх залуучуудын үнэлгээ



Залуучуудаас Монгол Улсын Их Хурал болон орон нутгийн ИТХ-ын байгууллагад залуучуудын төлөөлөл хангагдаж чадаж байгаа эсэхийг тодруулахад 13,3 хувь нь Монгол Улсын Их Хуралд залуучуудын төлөөлөл хангагдаж чадаж байна, 54,5 хувь нь хангагдаж чадахгүй байна гэж үзжээ. Харин Улсын Их Хуралд залуучуудын төлөөлөл

хангагдаж чадаж байгаа эсэх талаар 32,2 хувь нь мэдэхгүй гэжээ. Залуучуудын 15,5 хувь нь оршин суугаа газрынхаа орон нутгийн ИТХ-ын байгууллагад залуучуудын төлөөлөл хангагдаж чадаж байна гэж үзсэн бол 45,2 хувь нь чадахгүй байна гэж үзжээ. Мөн залуучуудын 39,3 хувь нь энэ талаар мэдэхгүй гэж хариулжээ.

Зураг 36. Дараах байгууллагуудад залуучуудын төлөөлөл хангагдаж чадаж байна уу?



Сонгуулийн оролцоо.

Залуучуудын өмнөх сонгуулиудад оролцсон оролцоог тухайн шатны сонгуулийн зохион байгуулагдсан он тус бүрээр нь асууж Ерөнхийлөгчийн сонгууль, УИХ-ын сонгууль, Орон нутгийн ИТХ-ын сонгуулиудад залуучуудын оролцоо ямар байсныг тодорхойлохыг зорилоо.

Ерөнхийлөгчийн сонгууль. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль өнгөрсөн хугацаанд 2001, 2005, 2009, 2013 онуудад дөрвөн удаа зохион байгуулагдсан байна. 2001 онд судалгаанд хамрагдсан залуучуудын 12,3 хувь нь, 2005 онд 25,9 хувь нь, 2009 онд 46,7 хувь нь, 2013 онд 66,8 хувь нь Ерөнхийлөгчийн сонгуульд оролцсон байна. Эндээс харахад Ерөнхийлөгчийн сонгуульд оролцож буй залуучуудын оролцоо сонгуулийн жилүүдэд тогтмол 20 орчим хувиар өссөн зураглал ажиглагдаж байна.

Улсын Их Хурлын сонгууль. Өнгөрсөн хугацаанд УИХ-ын сонгууль 2000, 2004, 2008, 2012 онуудад дөрвөн удаа зохион байгуулагдсан байна. 2000 оны Улсын Их Хурлын сонгуульд судалгаанд хамрагдагсадын 12,6 хувь нь оролцсон, 78,2 хувь нь оролцоогүй, 9,2 хувь нь санахгүй байна гэж хариулжээ. Дээр дурьдсан онуудад зохион байгуулагдсан Улсын Их Хурлын сонгуулиудад залуучуудын оролцоо ямар байсныг судалгааны үр дүнгээс харвал 2000 онд 12,6 хувь, 2004 онд 24,5 хувь, 2008 онд 45,2 хувь, 2012 онд 64,0 хувь байсан байна. Судалгаанд хамрагдсан залуучуудын тухайд УИХ-ын сонгуулийн оролцоо сонгуулийн жилүүдэд 20 орчим хувиар тасралтгүй өссөнийг харуулж байна. 2000 оны сонгуулийн залуучуудын оролцоог хамгийн сүүлд буюу 2013 онд зохион байгуулагдсан УИХ-ын сонгуультай харьцуулж үзвэл УИХ-ын анхны сонгуулиас


залуучуудын оролцоо 50 гаруй хувиар нэмэгдсэн байна. Гэтэл бодит байдал дээр 2012 оны Улсын Их Хурлын сонгууль дахь залуучуудын ирц 41 хувьтай байсныг энд тэмдэглэх нь зүйтэй.

Орон нутгийн ИТХ-ын сонгууль. Орон нутгийн ИТХ-ын сонгууль 2000, 2004, 2008, 2012 онуудад дөрвөн удаа зохион байгуулагдсан байна. 2000 оны орон нутгийн сонгуульд судалгаанд хамрагдсан залуучуудын 9,1 хувь нь оролцож байсан бол 81,8 хувь нь оролцоогүй гэж хариулсан байна. Залуучуудын орон

нутгийн сонгуульд оролцсон байдлыг сонгууль зохион байгуулагдсан онуудаар харьцуулж үзэхэд 2000 онд залуучуудын 9,1 хувь, 2004 онд 17,2 хувь, 2008 онд 29,9 хувь, 2012 онд 43,8 хувь нь сонгуульд оролцсон байна. Энэ үр дүнг нэгтгэж үзвэл орон нутгийн ИТХ-ын сонгуульд залуучуудын оролцоо тасралтгүй өссөн байна. 2000 оны ИТХ-ын сонгууль дахь залуучуудын оролцоог 2012 оны сонгуулийн оролцоотой харьцуулж үзвэл залуучуудын оролцоо 34,7 хувиар өсчээ.

Зураг 37. Өмнөх сонгуулиудын залуучуудын оролцоо

Ерөнхийлөгчийн сонгууль



Оролцсон


Оролцоогүй

Санахгүй байна


70



УИХ-ын сонгууль



Орон нутгийн ИТХ-ын сонгууль



ДҮГНЭЛТ

Судалгааны үр дүнд тулгуурлан дараах үндсэн дүгнэлтүүдийг хийлээ. Үүнд:

- 18-35 насын залуучуудын улс төрийн оролцоо харьцангуй сул (статистик дундаж утга нь 1,72) байна. Гурван залуу тутмын нэг нь улс төрд огт оролцохгүй байна.
- Залуучуудын улс төрд итгэж байдал сул байна. Мөн тэдний оролцох сонирхол харьцангуй сул байгаа нь 18-20 насны залуучууд буюу шинэ сонгогчийн хувьд мөн адил ажиглагдаж байгаа бөгөөд зарим талаар залуучуудын бусад (насны бүлэг)-аас ялгаатай байгаа нь сонгогчийн зан үйл төлөвших үйл явц хангалтгүй байдгийн илэрхийлэл гэж үзэж болох байна.
- Судалгаанд хамрагдсан залуучуудын хувьд төр засгийн удирдлагад итгэх итгэл хийгээд тэдний улс төрийн амьдралд нөлөөлөх, оролцох идэвх аль аль нь төдий л өндөр биш, гэхдээ зарим талаараа хүн амын бусад бүлгээс арай илүү дүр зураг харагдаж байна.
- Улс төрийн оролцооны хэлбэрээр нь авч үзвэл нийцгүй оролцооны хэлбэр давамгайлах хандлага бий болжээ. Залуучуудын олонхи нь улс төрийн өнөөгийн амьдралыг хэт эмх замбараагүй улс төрийн хоосон шоуны шинжтэй болсон гэж үзэж байна.
- Залуучуудын улс төрийг сонирхдоггүй байдалд хамгийн сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлд улс төр, улс төрчдөд итгэдэггүй гэсэн шалтгаан голлох хүчин зүйл болсон байна.
- Залуучуудын улс төрийн болон сонгуулийн тухай мэдээлэл авдаг мэдээллийн гол эх сурвалж нь телевиз, интернэт, сонин хэвлэл байгаа бөгөөд тэд энтертаймент мэдээ мэдээлэл илүү их сонирхдог дүр зураг харагдлаа.
- 18-35 насны залуучуудын хувьд сонгуулийг ардчилалын чухал үнэт зүйл, иргэдийн улс төрийн оролцооны үндсэн хэлбэр, өөрсдийн дуу хоолойг төрд хүргэх

боломж гэж үзэх ерөнхий суурь ойлголт, төсөөлөл бүрэлдэн тогтсон байгаа нь харагдлаа. Хэдий тийм боловч тэдний 20 орчим хувь нь сонгуулийг бохир аргаар төрд шургалах оролдлого, сонгогчдын саналыг худалдан авах үйлдэл, сонгогчдыг төөрөгдүүлэх, хууран мэхлэх явуулга гэсэн сөрөг хандлагатай байна. Өнгөрсөн сонгуулиудыг шударга, хараат бус, чөлөөт сонгууль болсон гэж үнэлэх хандлага маш бага байна.

- 18-35 насны залуучуудын сонгуулийн оролцоо харьцангуй өндөр байна. Залуучуудын сонгуульд оролцохгүй байх шалгаан нь итгэл хүлээсэн нам, улс төрч байхгүй, улс төр сонирхдоггүй, сонгох нам улс төрч байхгүй, улс төрд итгэхгүй байгаа байдал гэжээ. Эндээс харахад залуучуудын хувьд улс төрийн нам, улс төрчид сонгогчдын итгэл хүлээхгүй байгаа нь тэдний улс төрийн оролцоонд сөргөөр нөлөөлдөг гэсэн дүгнэлтийг хийж болохоор байна.
- Судалгаанд хамрагдсан гурван залуу тутмын хоёр нь өнгөрсөн хугацаанд ямар нэг сонгуульд оролцож байсан бөгөөд 70

гаруй хувь нь удахгүй болох 2016 оны УИХ-ын сонгуульд оролцоно гэсэн байна.

- Залуучуудын нас, боловсролын түвшин нэмэгдэхийн хэрээр сонгуулийн оролцоо нэмэгдэх зүй тогтол ажиглагдаж байна.
- Хөдөө орон нутгийн залуучуудын сонгуулийн оролцоо Улаанбаатар хотын залуучуудын сонгуулийн оролцооноос харьцангуй өндөр байхаар байна.
- Залуучуудын улс төрийн оролцоо сул байгаа нь улс төрийн үйл явцын ач холбогдлын талаарх тэдний ойлголт, төсөөлөл дутмаг, улс төрийн намууд, улс төрчид итгэл төрүүлэхгүй байгаатай холбоотой нь тодорхой харагдаж байна.
- Залуучуудын дийлэнх нь улс төрийн өнөөгийн нөхцөл байдлыг хэт замбараагүй, сонгууль дөхөөд шоу хийсэн байдалтай байна гэж сөргөөр үнэлж байна.
- Залуучуудын дийлэнх нь улс төрийн оролцооны хамгийн түгээмэл хэлбэр болох сонгуульд саналаа өгч оролцох хэлбэрийг сонгож улс төрд оролцож байна. Үүний зэрэгцээ фэйсбүүк, твиттерээр санал, бодлоо илэрхийлж

оролцох хандлага өндөр байгаа бөгөөд үүнийгээ улс төрийн оролцооны нэг хэлбэр гэж ойлгож байна. Энэ нь цахим ертөнцийн хэрэглээ залуучуудын дунд өндөр байгаатай холбоотой байж болох юм. Харин залуучууд улс төрийн намыг идэвхитэй дэмжиж оролцох, улс төрийн намын гишүүний хувиар оролцох хэлбэрээр улс төрд оролцох хандлага маш бага байна.

- Залуучуудын сонгуулийн талаарх мэдээлэл авдаг гол эх сурвалж нь телевиз байна. Үүний зэрэгцээ фэйсбүүк хуудас, сурталчилгааны самбараас хамгийн их мэдээлэл авдагаа илэрхийлсэн байна. Харин нэр дэвшигчийн сонгуулийн штаб, нэр дэвшигчтэй хийсэн уулзалт, гар утасны мессэж, твиттерээс мэдээлэл бага авч байгаа нь харагдлаа.
- Залуучууд сонгуульд саналаа өгөхдөө сонгуулийн өмнөх жилүүдийн улс төрийн нөхцөл байдал, нэр дэвшигч, нам, мөрийн хөтөлбөрийг чухалчилан үзэж сонголтоо хийдэг байна.
- Залуучууд өөрийг нь төлөөлөн ажиллах улс төрчийг хэлсэн үгэндээ эзэн болдог,

боловсрол, мэдлэгээрээ сонгогчдын итгэл, дэмжлэгийг хүлээсэн, хариуцлага хүлээх чадвартай хүн байгаасай гэсэн хүлээлттэй байна. Харин нэр дэвшигч нутаг усны, олонд танигдсан нэр хүндтэй, намдаа тууштай үнэнч байх эсэх нь залуучуудад чухал биш байна.

- Залуучуудын нас нэмэгдэх тусам ухамсартай, бие даасан сонголт хийх хандлага нэмэгдэж байна. Харин сонгуульд нэр дэвшигчийн талаарх хүлээлтийн хувьд 18-20, 21-25 насны бүлгийнхэн нэр дэвшигчийн хувь хүний шинжүүдийг чухалчилан үзэж байгаа бол 26-30 насныхан нэр дэвшигчийг улс төрчийн шинжүүдийг нь илүү чухалчилан үздэг гэсэн байна. 31-35 насныхан улс төрч байхаас гадна тодорхой хийсэн ажилтай, ажил хийж чадах хүнийг дэмжих хандлагатай байдаг байна. Өөрөөр хэлбэл нас нэмэгдэхийн хэрээр нэр дэвшигчийн хүлээлтийн хувьд улс төрч хүний шинжүүд нь бүрэлдэн тогтсон, тодорхой хийсэн ажилтай, ажил хийж чадах хүнийг байгаасай гэсэн хүлээлт нь нэмэгдэж байна.

ЗӨВЛӨМЖ

1. Улс төрийн үйл явц, оролцооны ач холбогдолыг таниулах, ойлгуулах, мэдээллээр хангах үйл ажиллагаа зохион байгуулах нь залуучуудын улс төрийн оролцоог нэмэгдүүлэх практик арга зам болно.
2. Залуучуудын улс төрийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд нэг талаас, юуны урьд засаг төрийн тунгалаг, ил тод байдал, хуулийн өмнө бүгд тэгш эрхтэй байх, нийгмийн шударга ёсны зарчмыг хэрэгжүүлэх, төрийн гол үүрэг болох ард түмэндээ үйлчлэх, ард олны хүлээж буй зүйлд мэдрэмжтэй хандахад анхаарлаа хандуулах, нөгөө талаас нийт иргэд ялангуяа залуучуудад иргэний боловсрол олгох ажлыг төрийн бодлогын хэмжээнд тавьж хэрэгжүүлэх шаардлагатай.
3. Залуучуудын улс төрийн оролцоог нэмэгдүүлэх сургалтын модуль боловсруулж, зорилтот бүлэгт чиглэсэн хэлбэрээр ашиглах бодит шаардлага ажиглагдаж байна.
4. Залуучуудын улс төрийн оролцоонд улс төр, эрх зүйн орчин нөлөөлж байгаа эсэхийг үнэлэх судалгаа хийж, залуучуудын улс төрийн оролцоонд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг бүрэн судалж, үр дүнд нь тулгуурлан оролцоог нэмэгдүүлэх ажил зохион байгуулах хэрэгтэй байна.
5. Цаашид залуучуудын сонгуулийн зан үйлийг тодорхойлох макро, микро түвшиний судалгаа хийх нь онолын болон практик ач холбогдолтой байх болно гэж үзэж байна. Залуучуудын улс төрийн оролцооны төлөв байдал, түүнд нөлөөлж буй хүчин зүйлүүдийн талаарх нарийвчлсан судалгааг тогтмолжуулах, мэргэшсэн судлаачдыг бэлтгэх, залуучуудын болон судалгаа шинжилгээний байгууллагуудад түшиглэн тэдэнд чиглэсэн суурь судалгаа хийх.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Хууль

- Монгол улсын үндсэн хууль. УБ., 1992.
- Монгол улсын боловсролын тухай хууль. УБ., 2002.
- Сонгуулийн тухай хууль. УБ., 2015.
- Сонгуулийн төв байгууллагын тухай хууль. УБ., 2006.

УИХ, Засгийн газрын тогтоол

- Залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр. Засгийн газрын 2006 оны 282 дугаар тогтоол
- Жендерийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр. Засгийн газрын 2002 оны 274 дүгээр тогтоол
- Монгол Улсын Засгийн Газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр. УИХ-ын 2012 оны 37 дугаар тогтоол
- Монгол улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого. УИХ-ын 2004 оны 21 дүгээр тогтоол

- Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэл. УИХ-ын 2012 оны 37 дугаар тогтоол
- Монгол улсын мянганы хөгжлийн зорилтыг батлах тухай. УИХ-ын 2005 оны 25 дугаар тогтоол
- Монгол улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого. УИХ-ын 2008 оны 12 дугаар тогтоол
- Монгол улсын мянганы хөгжлийн зорилтууд. УИХ-ын 2008 оны 13 дугаар тогтоол
- “Монгол залуу хүн” үндэсний хөтөлбөр. ЗГ-ын тогтоолын төсөл, 2015

Нэг сэдэвт бүтээл

- Бат-Өлзий Б., XXI зуун-монголын залуучууд. УБ., 2011.
- Ганболд, Ц., Улс төрийн шинжлэх ухаан.УБ., 2001.
- ГХЯ, НҮБХХ, Ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудын олон улсын тавдугаар бага хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх төсөл,

Ардчилсан засаглалын шалгуур үзүүлэлт: Монгол дахь засаглалын төлөв байдал, үнэлгээ. УБ., 2006.

- Даваадулам, Ц., Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичиг. УБ., 2010.
- Довчин, Ё., Харьцуулсан улс төр. УБ., 2006.
- Довчин, Ё., Улс төрийн үг хэллэг, нэр томъёоны толь. УБ., 2005.
- Жаргал, Ж., Сарангэрэл, Л., Улс төрийн шинжлэх ухаан. УБ., 2012.
- Зүльфикар, З., Алтанцэцэг, Б. нар, Монгол улсын улс төр, эдийн засаг, нийгэм: тогтолцоо ба бодлого. УБ., 2013.
- Монгол улсын хүүхэд, эмэгтэйчүүд: өнөөгийн байдал, ирээдүйн зорилтууд /гарын авлага/. УБ., 2007.
- Улс төр ба иргэдийн оролцоо. УБ., 2010.
- МУСЕХ, Монгол улсын ерөнхийлөгчийн сонгуулийн дүн /1993-2013/. УБ., 2013.
- МУСЕХ, Монгол улсын их хурлын сонгуулиудын дүн /1992-2012/. УБ., 2013.
- Мянганы хөгжлийн зорилт 9: Хүний эрх, ардчилсан засаглалыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх төсөл, Хүний эрхийг хангаж ардчилсан засаглалыг бэхжүүлэх мянганы хөгжлийн зорилго. Үндэсний зөвлөлдөх уулзалтын илтгэлийн эмхтгэл, УБ., 2008.
- НҮБХХ, Монгол улсад үзүүлсэн сонгуулийн туслалцааны сургамж, 2008-2012. УБ., 2013.
- Политологи: Эрдэм шинжилгээний бичиг, №246 (28). УБ., 2005.
- Политологи: Эрдэм шинжилгээний бичиг, №10 (388). УБ., 2013.
- Политологи: Эрдэм шинжилгээний бичиг, №11 (402). УБ., 2014.
- Эмнести интернэшнл, Залуучуудын оролцоо - идэвхжилт-үйл ажиллагаа. УБ., 2014
- Содномгомбо, Д., Найдансүрэн, Ч., Улс төрийн соёл, түүний монгол дахь төлөвшлийн асуудал. УБ., 2000.
- Сонгогчдын боловсрол төв, Конрад-Аденауэр-Сан, Иргэний танхим-Иргэдийн оролцоо. Гарын авлага, УБ., 2015.
- Сургалт, судалгааны прогноз төв, ХБНГУ-ын Фридрих Эбертийн сан, Улс төр ба иргэдийн оролцоо. УБ., 2010.
- Тамир, Ч., Монголын сонгогчдын онцлог. УБ., 2004

- Толя, Л., Улс төр судлал. УБ., 2012.
- Улс төр ба иргэдийн оролцоо. Сургалт судалгааны прогноз төв, Удирдлагын академи. УБ., 2010.
- Иргэдийн оролцооны эрх зүйн орчин ба үнэлгээ. Улс төрийн боловсролын академи, УБ., 2013.
- Иргэн таны оролцоо-Ардчиллын баталгаа. Улс төрийн боловсролын академи, УБ., 2003.
- Улс төр судлал. ШУТИС, УБ., 2014.
- Монгол дахь сонгуулийн үйл явц: Онол, практик, Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл. УБ., 2009
- Улс төрийн боловсролын академи, Зүүн азийн барометр. УБ., 2005.
- Удирдлагын академи, Конрад-Аденауэр-Сан, Ардчилалд иргэдийн идэвхи, оролцоо чухал болох нь. УБ., 2015.
- Цанжид, А., Улс төрийн шинжлэх ухааны үндэс. УБ., 1992.
- Цолмонтуяа, Н., Пагма, А., Сонгогчдын боловсрол: сургалтын гарын авлага /Сургагч багш нарт зориулав/. УБ., 2008.
- Чулуунбаатар, Г., Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилт. УБ., 2007.
- ШУА, ФСЭХ, НҮБХХ, Мянганы хөгжлийн зорилт 9: Хүний эрх, ардчилсан засаглалыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх төсөл, Ардчилсан засаглалын төлөв байдалд гарсан өөрчлөлт, 2009-2010. УБ., 2010.
- ШУА, ФСЭХ, НҮБХХ, Мянганы хөгжлийн зорилт 9: Хүний эрх, ардчилсан засаглалыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх төсөл, Ардчилсан засаглалын төлөв байдалд гарсан өөрчлөлт 2007-2008. УБ., 2008.
- Эмэгтэйчүүдийн эрх ба жендэрийн тэгш байдал, хүний эрхийн үндэсний байгууллагуудад зориулсан гарын авлага. УБ., 2013.

Судалгааны тайлан

- Батсүх, Ш., Долгоржав, Я., Ганцоож, Б., Шууд ардчилал-Иргэдийн оролцоо. Судалгааны тайлан, УБ., 2014.
- МУЗГ, НҮБХХ, Монголын Улс төр судлалын холбоо, Сонгуулийн талаарх олон нийтийн үзэл бодол. Судалгааны тайлан, УБ., 2005.
- Монгол улсын сонгуулийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх нь төсөл, Иргэний сонгогчийн боловсрол. Судалгааны тайлан, УБ., 2007.

- Нарантунгалаг Б., Сонгогчдын үйл байдал: Оролцоо, нөлөөлөх хүчин зүйлс, Магистрын ажил, МУИС, НШУС, Улс төр судлалын тэнхим. УБ.,2014.
- Нээлттэй нийгэм форум, Залуучуудын бодлого. Судалгааны тойм, УБ., 2010.
- Нээлттэй нийгэм форум, Парламентад бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь. Судалгааны тайлан, УБ., 2006
- Улс төрийн боловсролын академи, Иргэдийн оролцооны эрх зүйн орчин ба үнэлгээ. Судалгааны тайлан, УБ., 2013.
- Содног, Ш., “Сонгогчдын үйл байдлын өөрчлөлт: хүчин зүйл ба хандлага”. МУИС, НШУС, Политологи, Эрдэм шинжилгээний бичиг, УБ., 2005, №246 /28/
- Төгөлдөр, Я., Монголын эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны өнөөгийн байдлын шинжилгээ. МУИС, НШУС, Политологи, Эрдэм шинжилгээний бичиг, УБ., 2013, №/10/388

Гадаад хэлээр

Нэг сэдэвт өгүүлэл

- Загджав, Д., “Монгол дахь иргэдийн улс төрийн оролцооны өөрчлөлт” (Улс төрийн шинжлэх ухааны доктор [Ph.D]-ын зэрэг горилсон диссертаци). Монгол улсын шинжлэх ухааны академийн философи, социологи, эрхийн хүрээлэн, Улаанбаатар их сургууль, УБ., 2002, 24-30 дахь тал
- Одгэрэл, Б., Улс төрийн шийдвэр гаргах түвшинд Монголын эмэгтэйчүүдийн оролцоо: төлөв байдал, чиг хандлага. МУИС-шинжлэх ухааны сургуулийн нийгмийн ухааны салбар, УБ., 2014.
- Fiona Mary Robertson, A Study of Youth Political Participation in Poland and Romania, Thesis of Doctor of Philosophy, University College London, 2009.
- Maria Eremenko, National Research University – Higher School of Economics “Political participation: Model by Verba in the EU and Russia”. <http://www.culturaldiplomacy.org/academy/content/pdf/participant-papers/eu/Maria-Eremenko-Political-participation-Model-by-Verba-in-the-EU-and-Russia.pdf> [retrived in 20 April, 2016]
- “Youth, political participation and decision-making”, “What is political participation”. <http://www.un.org/esa/socdev/documents/youth/fact-sheets/youth-political-participation.pdf>, [retrived in 24 April, 2016]

- Inta Mierina, "Political participation and development of political attitudes in post-communist countries", University of Latvia faculty of social sciences department of sociology, Thesis of Doctor of Philosophy, RICA, 2011.
- "Will They Engage? Political Knowledge, Participation and Attitudes of Generations X and Y", Germany, 2001.
- Fiona Mary Robertson, "A Study of Youth Political Participation in Poland and Romania", University College London. 2009.
- Lester W. Milbrath and M. L. Goel, *Political Participation*, 2nd ed. (Chicago: Rand McNally, 1977)
- Rosenstone and John Mark Hansen, *Mobilization, Participation, and Democracy in America* (New York: Macmillan, 1993)
- Sidney Verba, Kay Lehman Schlozman, and Henry E. Brady, *Voice and Equality: Civic Voluntarism in American Politics* (Cambridge, MA: Harvard University Press, 1995)
- Steven J. Rosenstone and John Mark Hansen, *Mobilization, Participation, and Democracy in America* (New York: Macmillan Publishing Company, 1993)
- Frances Fox Piven and Richard A. Cloward, *Why Americans Still Don't Vote* (Boston: Beacon Press, 2000)
- William H. Flanigan and Nancy H. Zingale, *Political Behavior of the American Electorate*, 9th ed. (Washington, DC: CQ Press, 1999).
- Erol Turan, *Siyasal Sistem Davranişi*, Konya, Palen Zuyinlaci, 2010.
- Cengiz Çağlayan. *Siyaset Bilimine Giriş*, İstanbul, Etkilesim, 2015 .
- Koray, Meyrem, *Günümüzde Yaklaşım Işığında Kadınlar ve Siyaset*, İstanbul: TUSES Yayınları, 2015.
- Kalaycioglu, *Çağdaş Siyasal Bilim: Teori, Olgu ve Süreçler*, Ankara 1994.

Вэб сайт

- www.legalinfo.mn
- www.parliament.mn
- www.gec.gov.mn
- www.mas.ac.mn
- www.forum.mn
- www.academy.org.mn



www.kas.de/mongolei
www.facebook.com/kas.mongolei